

Германы Бундестагийн
тогтоолын үндсэн дээр
хөхиүлэн дэмжсэн:



Холбооны
Хүнс,
хөдөө аж ахуйн яам



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТӨРИЙН БОДЛОГЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨШҮҮРГИЙН СУДАЛГАА



Герман-Монголын хамтын ажиллагааны
Тогтвортой хөдөө аж ахуй төсөл

Доктор, профессор А.БАКЕЙ
2021 он



Герман-Монголын хамтын ажиллагааны
Тогтвортой хөдөө аж ахуй төсөл

ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТӨРИЙН БОДЛОГЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨШҮҮРГИЙН СУДАЛГАА



ГАРЧИГ

ОРШИЛ	3
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ	5
1.1. Онолын үндэслэл.....	5
1.2. Практик шаардлага, үндэслэл	6
1.3. Хамрах хүрээ, арга зүй	6
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫГ ДЭМЖИХ ТӨРИЙН БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ	9
2.1. Төрийн бодлогын үндсэн чиглэл, агуулга.....	9
1.2. Урамшуулал, дэмжлэгийн эрх зүйн орчны шинжилгээ	12
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫГ ДЭМЖИХ ЭДИЙН ЗАСГИЙН ХӨШҮҮРГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ	21
3.1. Санхүүгийн дэмжлэгийн өнөөгийн байдал	21
3.2. Орцын дэмжлэгийн өнөөгийн байдал	26
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨШҮҮРГИЙГ САЙЖРУУЛАХ БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ, ҮР ДҮН	37
4.1. Хөдөө аж ахуйн хөгжлийг дэмжих сангийн үйл ажиллагааны талаар.....	37
4.2. Улаанбуудайн урамшууллын талаар өгөх бодлогын зөвлөмж	37
4.3. Үнийн, зээлийн болон татварын чөлөөлөлт, хөнгөлөлтийн хөшүүргийн талаар өгөх бодлогын зөвлөмж	38
ХАВСРАЛТУУД	41
Хавсралт 1. Асуулгын хуудас	41
Хавсралт 2. Асуулгын судалгаанд оролцогчид	44
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	46

ОРШИЛ

Хөдөө аж ахуй, түүний дотор газар тариалангийн үйлдвэрлэл бол хүн амыг хүнсээр хангадаг хүнсний үйлдвэрлэлийн анхдагч мөнхийн салбар билээ. Өнөөдөр дэлхийн аль ч улс орны төр засгийн нэн тэргүүний чиг үүргийн нэг нь хүн амаа тэжээллэг, аюулгүй хүнсээр хүртээмжтэй хангах асуудал байдаг.

Улсын Их Хурлаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 8.3-д¹ “Хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ” хэмээн тус салбарын тогтвортой хөгжлийн зорилтыг тодорхойлсон бол энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд газар тариалангийн салбарын хөгжлийн талаар “Тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, голлох нэр төрлийн тарималаар дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, бусад ашигт таримлын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ” гэж заажээ.

Хүн амыг хүнсээр, мал сүргийг тэжээлээр, боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангадаг эдийн засгийн нэн чухал салбар – газар тариалангийн үйлдвэрлэлийн хөгжилд төрөөс багагүй дэмжлэг үзүүлж ирсэн билээ. Иймд энэхүү чухал салбарын хөгжлийг төрийн зүгээс дэмжиж ирсэн бодлого, эрх зүйн орчин, нөлөөллийн өнөөгийн байдлыг судалж, үнэлэлт дүгнэлт өгөх, бодлого боловсруулагчид болон шийдвэр гаргагчдад зохих зөвлөмж санал болгох нь чухал ач холбогдолтой юм.

Энэхүү бодит эрэлт хэрэгцээг харгалзан Герман-Монголын “Тогтвортой хөдөө аж ахуй” төсөл (MNG 19-01)-тэй байгуулсан богино хугацаат гэрээний дагуу “Тариалангийн салбарын хөгжлийг дэмжих төрийн бодлогын эдийн засгийн хөшүүргийн судалгаа” -г хийж гүйцэтгэлээ. Уг гэрээт судалгааны ажлын зорилго нь тариалангийн хөгжлийг дэмжих дэмжлэгийн макро болон микро эдийн засгийн орчинд үнэлгээ хийж, төрийн дэмжлэг, урамшууллын бодлогыг сайжруулах чиглэлээр зөвлөмж боловсруулахад оршино.

Судалгааны ажлын тайлан нь үндсэн дөрвөн бүлэг, хавсралт хэсгээс бүрдэж байна. Нэгдүгээр бүлэгт судалгааны ажлын үндэслэл, хамрах хүрээ, арга зүйн талаар; хоёрдугаар бүлэгт тариалангийн салбарыг дэмжих төрийн бодлого, эрх зүйн орчны шинжилгээг; гуравдугаар бүлэгт тариалангийн салбарыг дэмжих эдийн засгийн хөшүүргийн өнөөгийн байдлын шинжилгээг; дөрөвдүгээр бүлэгт эдийн засгийн хөшүүргийг сайжруулах бодлогын зөвлөмж, үр дүнгийн талаар тус тус тусгасан болно. Хавсралт хэсэгт асуулгын судалгааны хуудасны загвар болон асуулгад оролцогчдын бүрэлдэхүүний талаарх мэдээллийг орууллаа.

Судалгааны ажлыг гүйцэтгэхдээ газар тариалангийн үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээнд оролцогч талууд болох төв, орон нутгийн төрийн захиргааны холбогдох байгууллага, албан тушаалтан, мэргэжилтнүүд, тариалангийн үйлдвэрлэл, бизнес эрхлэгчид, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын судлаачид, мэргэжлийн

холбоодын төлөөллийг оролцуулан Google form-оор асуулгын судалгаа авах, заримтай нь биечлэн уулзаж урьдчилан бэлтгэсэн асуултаар фокус ярилцлага хийх замаар анхдагч мэдээллийг цуглуулав. Асуулгын судалгаанд нийтдээ 63 хүн оролцсон бөгөөд тэдний 66.7 хувь нь газар тариалангийн үйлдвэрлэл, бизнес эрхлэгчид; 19.0 хувь нь судлаачид; 14.3 хувь нь бусад холбогдох хүмүүс байв (Хавсралт 2-ыг үзнэ үү). Фокус ярилцлагад ХХААХҮЯ-ны 8 мэргэжилтэн, салбарын бизнес эрхлэгч 12 хүн хамрагдав. Мөн тус салбарын хөгжлийг төрөөс дэмжих чиглэлийн эрх зүйн орчны болон статистик тоон мэдээллийг УИХ, Засгийн газар, Үндэсний статистикийн хороо, ХХААХҮЯ, Хөдөө аж ахуйг дэмжих сан зэрэг байгууллагын албан ёсны эх сурвалжаас авч ашиглав.

Уг судалгааны тайлан дахь тариалангийн салбарын хөгжлийг дэмжих төрийн бодлогын эдийн засгийн хөшүүргийн өнөөгийн байдлын талаарх үнэлэлт, дүгнэлт болон цаашид сайжруулах зөвлөмжүүдийг хөдөө аж ахуйн, түүний дотор газар тариалангийн бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид албан ажилдаа хэрэглэх боломжтой гэж үзэж байна.

Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэхэд бидэнд дэмжлэг үзүүлж хамтран ажилласан Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” төслийн нэгж, ХХААХҮЯ-ны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын болон Хөдөө аж ахуйг дэмжих сангийн мэргэжилтнүүд, мөн өөрсдийн үнэт саналаа хуваалцсан санал асуулгад оролцогчдод гүн талархал дэвшүүлье!

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

1.1. Онолын үндэслэл

Хоол, хүнсний ханамж бол хүн төрөлхтний нэн чухал мөнхийн асуудал бөгөөд уг асуудалд олон жилийн турш эрдэмтэн судлаачид, улс гүрэн бүрийн төр засгийн зүгээс байнга анхаарал хандуулж иржээ. Шинжлэх ухаан технологи эрчимтэй хөгжиж буй XXI зуунд ч хүн амын хүнс, тэжээлийн хангамж, аюулгүй байдлыг хангахад хөдөө аж ахуйн салбарыг хэрхэн хөгжүүлэх үү, төрийн зүгээс юу хийвэл зохилтой вэ хэмээх асуулт хариулт нэхсэн хамгийн тулгамдсан асуудлын нэг хэвээр байна.

Хөдөө аж ахуй бол хөгжингүй болон хөгжиж буй орнуудын аль алинд нь төрийн зохицуулалтыг шаарддаг эдийн засгийн өвөрмөц бөгөөд цөөн салбарын нэг билээ. Эдийн засгийн онол ёсоор хөдөө аж ахуйн салбарт зах зээлийн зүй тогтлын механизм бүрэн утгаар үйлчилдэггүй, өөрөөр хэлбэл, үйлдвэрлэгчид нь хэмжээний хувьд хэт жижиг, эмзэг шинжтэй, өрсөлдөөн хязгаарлагдмал тул зах зээлийн нийлүүлэлт хангалтгүй, байгаль цаг уурын нөлөөлөл гэх мэт гадаад хүчин зүйлсийн нөлөө ихтэй зэрэг үндэслэлээр уг салбарын хөгжилд төрийн оролцоо, зохицуулалт шаардлагатай гэж үздэг. Хөдөө аж ахуй, хүнсний бүтээгдэхүүн нь зах зээлийн өрсөлдөөн болон байгаль цаг уурын хүчин зүйлийн улмаас нэлээд сорилт, бэрхшээлийг даван туулж байж сая нийгмийн баялаг болж хувирдаг онцлогтой. Үүнтэй холбоотойгоор энэ салбарт төрийн оролцоо, дэмжлэг зайлшгүй шаардлагатай гэж үздэг.

Олон арван жилийн турш хийгдсэн гадаад, дотоодын эрдэмтэн судлаачдын судалгаа шинжилгээний ажлын үр дүнд хөдөө аж ахуйн салбар дахь төрийн дэмжлэгийн үндэслэлүүд боловсруулагджээ.² Үүнд:

1. *Өөрийгөө хангах бодлогын үндэслэл.* Улс орон бүр хөдөө аж ахуйн гаралтай гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр өөрийгөө хангах бодлого нь хөдөө аж ахуйг төрөөс дэмжих бодлоготой шууд холбоотой байдаг. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг дэмжих замаар хүнсний аюулгүй байдал, хүртээмжийг дээшлүүлэх, хүнсний импортыг бууруулж, төлбөрийн тэнцлийг сайжруулах асуудал нь аль ч улсын төрийн бодлогын төвд байна.
2. *Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн орлоготой холбоотой үндэслэл.* Эдийн засгийн бусад салбаруудтай харьцуулахад хөдөө аж ахуй дахь орлого ерөнхийдөө буурах хандлагатай байдаг онцлогтой. Энэ нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн өсөлт харьцангуй доогуур тул тус салбарын үйлдвэрлэл эрхлэгчдийн орлогод сөрөг нөлөө үзүүлдэг. Иймд төрийн зохицуулалт зохих хэмжээгээр байх ёстой гэж үздэг.
3. *Хөдөө орон нутгийн хөгжилтэй холбоотой үндэслэл.* Олон зуун жилийн турш хөдөө аж ахуй нь хүн амын эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн төрөл

² А.Бакей “Хөдөө аж ахуйн эдийн засаг”, Улаанбаатар, 2014 он, хууд. 145-149

байж ирсэн боловч орчин үед аль ч улс орны хувьд үндэсний эдийн засагт уг салбарын эзлэх хувь буурсаар байна. Үүнтэй холбоотойгоор хөдөө орон нутаг дахь ажил эрхлэлт буурахын хэрээр хөдөөгийн соёл иргэншилд эрсдэл тулгардаг байна. Хөдөөгийн иргэд газар нутгаа хамгаалах, үндэсний өв соёл, уламжлалаа хамгаалах зорилгоор төрөөс хөдөө аж ахуйн хөгжлийг дэмжих үндэслэл чухамхүү энэ нөхцөлөөс урган гардаг.

4. *Байгаль орчныг хамгаалах үндэслэл.* Хөдөө аж ахуй бол байгаль орчинд багагүй сөрөг нөлөө үзүүлдэг салбаруудын нэг. Тухайлбал, газар тариалангийн үйлдвэрлэлийн бордоо, химийн бодис, газрын хөрсний элэгдэл, эвдрэл гэх мэт хүчин зүйлсийн улмаас хөдөөгийн экосистем доройтох хандлагатай байна. Иймд газар тариалангийн салбарт экологид ээлтэй технологи хэрэглэх явдлыг төрөөс дэмжих шаардлага тавигдаж байна.

1.2. Практик шаардлага, үндэслэл

Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлд газар тариалангийн салбар 10 гаруй хувийг эзэлдэг бөгөөд газар тариалангийн салбарыг 16.3 мянган өрхийн аж ахуй, 1.5 мянга орчим³ хувийн компани эрхлэн явуулж, хүн амыг гурил, төмс, хүнсний ногоо зэрэг хүнсний бүтээгдэхүүнээр, боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

Газар тариалангийн салбарт шинэ технологи, инновацийн нэвтрэлт удаашралтай байгаагийн улмаас тус салбарын бүтээмж, үр ашиг төдийлөн хангалттай бус байна.

Нөгөө талаар, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас тус салбарын үйлдвэрлэл эрхлэхэд учрах эрсдэл нэмэгдэх хандлагатай болж байна. Хэдийгээр төрөөс газар тариалангийн салбарын хөгжилд зохих дэмжлэг үзүүлж ирсэн боловч тэдгээрийн үр нөлөө болон үр дүнд иж бүрэн үнэлгээ өгөөгүй, цаашид боловсронгуй болгох чиглэл тогтоох талаар хийгдсэн судалгаа шинжилгээний ажил хомс байна. Үүнтэй холбоотойгоор салбарын бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, хүн амын хүнсний хэрэгцээг тогтвортой хангах үүднээс үйлдвэрлэгчдэд төрийн зүгээс үзүүлж ирсэн эдийн засгийн дэмжлэгийн өнөөгийн төлөв байдал, эрэлт хэрэгцээ, үр нөлөөний асуудлыг зайлшгүй судлан зөвлөмж боловсруулах шаардлагатай байна.

1.3. Хамрах хүрээ, арга зүй

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш хугацаанд төрийн зүгээс энэ салбарын хөгжлийг дэмжихэд төрийн бодлогын эдийн засгийн зарим хөшүүргийг хэрэглэж ирсэн байна. Тухайлбал:

1. *Төрөл бүрийн сангаар* (Тариалан эрхлэлтийг дэмжих сан (одоо Хөдөө аж ахуйн хөгжлийг дэмжих сан), Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан гэх мэт) дамжуулан *зээлийн бодлогоор дэмжих*

³ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын мэдээлэл, ХХААХҮЯ, 2021 он, хууд. 35

2. *Улсаас урамшуулал олгох* (үндэсний үйлдвэрт буудайн урамшуулал) төрийн бодлогын дэмжлэг
3. *Үйлдвэрлэлийн орцын* (үр, суулгац, бордоо, химийн бодис, шатахуун, трактор, комбайн, тоног төхөөрөмж гэх мэт) *нийлүүлэлтэд дэмжлэг* үзүүлэх
4. *Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөөр дэмжих* бодлого
5. *Бусад эх үүсвэр*, хэлбэрийн санхүүжилт (Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, гадаадын төсөл хөтөлбөрийн санхүүжилт гэх мэт)

Төр засгийн хөгжлийн бодлогын баримт бичигт хөдөө аж ахуйн салбарын, түүний дотор газар тариалангийн хөгжлийг дэмжих төрийн бодлогын хөшүүргүүдийн гол чиглэлийг тодорхойлсон байна. Гагцхүү уг хөшүүргүүдийн хэрэгжилтийн одоогийн төлөв байдалд шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлэлт дүгнэлт өгч, цаашид үр дүнтэй хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох нь чухал байна.

Иймд энэхүү судалгааны ажлаар манай орны газар тариалангийн салбарын хөгжлийг төрөөс дэмжиж ирсэн эдийн засгийн арга хөшүүргүүдийн (татвар, төсвийн татаас, хөрөнгө оруулалт, зээлийн бодлого, үнэ) хэрэгжилтийн байдалд шинжилгээ хийж, бодитой үнэлэлт дүгнэлт өгч, эдийн засгийн хөшүүргүүдийг цаашид боловсронгуй болгох талаар зөвлөмж, үндэслэл боловсруулахыг хичээв.

Энэхүү судалгааны ажлыг дараах арга зүйн дагуу гүйцэтгэсэн болно. Үүнд:

1. Газар тариалангийн салбарын хөгжлийг дэмжихтэй холбоотой төрийн бодлогын баримт бичгүүд, эрх зүйн орчныг зохицуулахтай холбоотой хууль тогтоомжуудын дэмжлэгийн агуулга, чиглэл, уялдаа холбоо зэрэгт харьцуулсан дүн шинжилгээ хийж, цаашид сайжруулах зөвлөмж боловсруулах;
2. Газар тариалангийн салбарын хөгжлийг дэмжиж ирсэн төрийн бодлогын эдийн засгийн гол хөшүүргүүдийн санхүүжилтийн эх үүсвэр, зориулалт, зарцуулалт, ашиг тус хүртэгсэд болон үр дүнтэй холбоотой хоёрдогч мэдээллийг Сангийн яам, ХХААХҮЯ, Хөдөө аж ахуйг дэмжих сан болон бусад холбогдох төрийн ба төрийн бус байгууллагуудын мэдээллийн сангаас авч, зохих үзүүлэлтүүдийн өөрчлөлт, бүтэц, үр дүнгийн байдалд статистик боловсруулалт хийж, дүгнэлт гаргах;
3. Газар тариалангийн салбарын хөгжлийг дэмжиж ирсэн төрийн бодлогын эдийн засгийн гол хөшүүргүүдийн одоогийн байдал, тулгамдсан асуудал, цаашид болгох асуудлаар урьдчилан бэлтгэсэн асуулгын хуудсыг Google Forms-р (Хавсралт 1-ийг үзнэ үү) дээрх байгууллагуудын холбогдох ажилтан, мэргэжилтэнд, мөн тариалангийн бизнес эрхлэгчдийн төлөөлөлд илгээж, бөглүүлэн авч, шинжилгээ хийж, зөвлөмжийн үндэслэлийг боловсруулах;
4. Салбарын зайлшгүй шаардлагатай зарим яамны албан тушаалтан, мэргэжилтнүүдтэй биечлэн уулзаж, судалж буй асуудлаар фокус ярилцлага хийж, тэдний санал бодлыг судалж, зөвлөмжид тусгах;
5. Энэхүү судалгааны ажлын захиалагч - Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” төслийн зүгээс гаргаж өгсөн Ажлын удирдамжийг

мөрдлөг болгон ажиллахын зэрэгцээ уг төслийн холбогдох ажилтанд судалгаа, боловсруулалтын ажлын явцыг танилцуулж, зөвлөгөө авч ажиллах.

Бидний арга зүйн дагуу газар тариалангийн үйлдвэрлэлийг төрөөс дэмжиж ирсэн байдлыг асуулгад оролцогчид хэр зэрэг мэддэг, ер нь энэ асуудалд хэрхэн ханддаг, тэд дэмжих шаардлагатай гэж үзэж байгаа бол үндэслэлийг нь хэрхэн үзэж байгаа талаар тэдний санааг тандаж асуусан асуултын хариулт дараах байдалтай байна.


“Газар тариалангийн хөгжлийг төрийн зүгээс эдийн засгийн хөшүүргээр хэрхэн дэмжиж ирсэн талаар Та өмнө нь мэддэг байсан уу?” гэсэн асуултад хариулсан 63 хариулагчийн 38.1 хувь нь энэ талаар сайн мэддэг, 11.1 хувь нь сонсож байсан, 50.8 хувь сайн мэддэггүй гэж хариулжээ.

“Ер нь газар тариалангийн хөгжлийг төрийн зүгээс эдийн засгийн хөшүүргээр дэмжих шаардлагатай гэж үзэж байна уу?” гэсэн асуултад асуулгад оролцогчдын 63.5 хувь нь зайлшгүй шаардлагатай, 31.7 хувь нь шаардлагатай, 4.8 хувь нь шаардлагагүй гэж хариулсан байна.

“Шаардлагатай гэж үзэж байгаа бол гол үндэслэл нь юу вэ?” гэсэн асуултад хэрхэн хариулсныг Зураг 1-ээс харж болно.

3. Шаардлагатай гэж үзэж байгаа бол гол үндэслэл нь юу вэ?

61 responses



Зураг 1. Газар тариалангийн үйлдвэрлэлийг төрөөс дэмжих үндэслэл

Газар тариалангийн салбарыг төрөөс дэмжихийн гол үндэслэлүүд дараах эрэмбэтэй байна. Үүнд:

1. Энэ салбар хүн амыг хүнсээр хангахад чухал ач холбогдолтой;
2. Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх нь их эрсдэлтэй;
3. Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх нь их хөрөнгө санхүү шаарддаг;
4. Уг салбар нь ажиллах хүч их шаарддаг тул ажилгүйдлийг бууруулахад онцгой үүрэгтэй.

Үүнээс үзэхэд, тус салбарын хөгжлийг төрийн зүгээс дэмжих үндэслэлийн талаарх бидний дэвшүүлсэн таамаглал зөв зүйтэй байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫГ ДЭМЖИХ ТӨРИЙН БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

2.1. Төрийн бодлогын үндсэн чиглэл, агуулга

Монгол Улсын хөгжлийн урт, дунд хугацааны хөгжлийн талаарх төрийн бодлогын баримт бичгүүдэд хөдөө аж ахуй, түүний дотор газар тариалангийн салбарын хөгжлийн талаар баримтлах бодлогын гол чиглэл тодорхойлогдсон байдаг. Энд зөвхөн газар тариалангийн хөгжлийг төрөөс хэрхэн дэмжих талаарх бодлогын үндсэн чиглэл, товч агуулгын талаар авч үзсэн болно.

“Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”⁴ (УИХ, №104, 2015). Энэхүү бодлогын баримт бичигт хүнс, хөдөө аж ахуйн салбарыг төрөөс дэмжихдээ баримтлах зарчмыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- хүн амыг шим тэжээллэг, аюулгүй хүнсээр жигд хүртээмжтэй хангасан байх;
- хүний нөөцийг тасралтгүй чадавхжуулсан байх;
- үйлдвэрлэл нь судалгаа ба хөгжилд тулгуурласан байх;
- хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжиж, хамгаалсан байх;
- үйлдвэрлэлийг үнэ цэнийн сүлжээгээр хөгжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлсэн байх;
- эрсдлийг бууруулахад чиглэгдсэн байх.

Мөн төрөөс хүнс, хөдөө аж ахуйг хөгжүүлэхэд: (i) ... хүн ам олноор суурьшсан хот, суурин газрын орчмын болон тариалангийн бүс нутагт ашиг шимийн чиглэлээр төрөлжсөн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх; (ii) уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон дэвшилтэт технологид суурилсан тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, тогтвортой хөгжүүлэх; (iii) мал аж ахуй, газар тариалангийн гаралтай түүхий эд, байгалийн баялгийг уламжлалт болон дэвшилтэт технологиор боловсруулж, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангасан шим тэжээллэг, баталгаатай хүнсээр хүн амыг тогтвортой хангах; (iv) хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй, мэдлэгт суурилсан тогтвортой хөгжлийн чиг баримжаатай хөгжүүлэх, инновацийг нэвтрүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх; (v) салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, үйлдвэрлэл эрхлэх менежментийг сайжруулах, тэдгээрийн тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрах ая тухтай нөхцөлийг бүрдүүлэх чиглэлийг баримтлахаар тусгажээ. Энэ нь тус салбарын хөгжлийн гол хүчин зүйлсийг багтаажээ.

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, үр ашигтай зарцуулах, худалдааг хөнгөвчлөх хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлэхээр тусгажээ:

- улсын төсвөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт зарцуулах хөрөнгийг улсын төсвийн 3-4 хувьд хүргэх;
- орон нутгийн төсвөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт зарцуулах хөрөнгийг хоёр дахин нэмэгдүүлэх;

⁴ <https://www.legalinfo.mn/law/details/11485>

- үнэ цэнийн сүлжээний санхүүжилтийн цогц бүтцийг бий болгож, шаардлагатай шатанд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх, үнэ цэнийн сүлжээг тэргүүлэгч аж ахуйн нэгжээр дамжуулан хөгжүүлэх;
- эрсдлийг бууруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг тогтворжуулахад даатгал, давхар даатгалын тогтолцоог цогц байдлаар нэвтрүүлэх;
- дэвшилтэт технологи нэвтрүүлэх, нутагшуулах, салбарын судалгаа ба хөгжлийн хөрөнгө оруулалтыг дэмжих;
- хүнс, хөдөө аж ахуйн салбарт санхүүгийн түрээсийн үйлчилгээг нэвтрүүлэх, төлөвшүүлэх;
- хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөрөнгө оруулалтыг бүс нутаг, ач холбогдол, чанар, бусад хүчин зүйлд суурилан эрэмбэлэн дэмжих;
- уул уурхайн татварын орлого, нөөц ашигласны болон тусгай зөвшөөрлийн төлбөрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарын судалгаа хөгжлийн сан бүрдүүлж, зарцуулах;
- дотоодын боловсруулах үйлдвэрлэлийг түүхий эдээр хангах үйл ажиллагааг дэмжих.

Дээр дурдсан хөрөнгө оруулалтын дэмжлэгийн чиглэлд хүнс, хөдөө аж ахуйн бусад салбарын нэгэн адил газар тариалангийн салбар хамрагдана.

“Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөр.⁵ Засгийн газрын 2017 оны 278 тоот тогтоолоор батлагдсан. Энэхүү хөтөлбөрт хүнсний ногооны салбарыг хөгжүүлэхдээ дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэхээр заасан байна:

- өвлийн хүлэмжийн аж ахуйг байгуулахад хөнгөлөлттэй нөхцөлөөр зээлийн дэмжлэг үзүүлж, хот суурингийн хүн амыг жилийн турш шинэ ургацын ногоогоор хангах;
- орон нутагт зуны нийлэг хальсан хүлэмж байгуулахад зориулж хөнгөлөлттэй нөхцөлөөр дэмжлэг үзүүлж, таримлын нэр төрлийг нэмэгдүүлэх;
- хүлэмжинд мөөг, ашигт таримал, гүзээлзгэнэ тариалахыг дэмжиж, гидропоник болон босоо тавиурт усан орчинд ногоо ургуулах дэвшилтэт технологийг нэвтрүүлж, нэгжийн ургацыг нэмэгдүүлэх;
- хөрсний үржил шимийг сайжруулах, нөхөн сэргээх, ургацын чанар, тоо хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор таримлын ургалтын үеийн био, органик, эрдэс бордоог хэрэглэхэд дэмжлэг үзүүлэх;
- хүнсний ногоог хатаах, хөлдөөх, хуурайшуулах дэвшилтэт технологийг нутагшуулах, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи турших, үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- хүнсний ногоо үйлдвэрлэгчийн захиалгаар бага, дунд оврын трактор, түүнд зориулсан чиргүүл дүүжин машин, мотоблок болон түүнд сольж угсардаг үрлэгч, арчлах, хураах техникийг нийлүүлэх ажлыг зохион байгуулах;
- хүнсний ногоог ялгаж дугаарлах, сортлох, савлах төхөөрөмж, гар багажны хангамжийг сайжруулах;

⁵ <https://www.legalinfo.mn/law/details/12881?lawid=12881>

- өрхийн тариалан эрхлэгчид сайн дураараа хорших, хуулийн этгээд байгуулах, нэгдсэн байдлаар техник, тоног төхөөрөмжийг худалдан авахад нь санхүү, эрх зүйн зөвлөмж болон зээл, хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
- хүнсний ногооны үйлдвэрлэлд ажиллаж байгаа залуу гэр бүл, залуучуудад гарааны болон санхүүгийн дэмжлэг олгож, ажлын байртай болгох, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;
- услалтын системийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг шинэчлэх, дэд бүтцийг сайжруулах замаар ногоочдын бүлэг, хоршоодыг дэмжин нэгж талбайгаас авах бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх;
- инженерийн хийцтэй томоохон услалтын систем бүхий иргэн, аж ахуйн нэгж таримлын сэлгээндээ хүнсний ногоо тариалах санаачилгыг дэмжих замаар үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх;
- байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй хөргөлт, халаалтын технологитой стандарт бүхий зоорийн аж ахуйг нэмэгдүүлэх;
- таримлын төрөлд зохицсон зориулалтын зоорь, агуулах байгуулах иргэн аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлж, импортыг бууруулах;
- хүнсний ногооны борлуулалтыг төрийн худалдан авалт (боловсрол, эрүүл мэнд, батлан хамгаалах, хууль сахиулах болон уул уурхай)-аар дэмжих бодлого, зохицуулалтын арга хэмжээ авах;
- ногооны үр үйлдвэрлэл эрхлэгчдэд үрсэлгээ бойжуулах зориулалтын хүлэмжийн аж ахуйг байгуулахад нь дэмжлэг үзүүлэх.

Энд хүнсний ногоон үйлдвэрлэлийн бараг бүх чиглэлийг багтаасан үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээр тусгасан боловч хэрэгжилтийн байдал төдийлөн сайн биш байна. Учир нь хүнсний ногоо эрхлэгчид гол төлөв өрхийн аж ахуйд тулгуурласан албан бус хөдөлмөр эрхлэлтийн шинжтэй тул тэдний талаарх мэдээллийн албан ёсны нэгдсэн сан байхгүй тул дэмжлэгийн гадуур үлддэг байна.

“Жимс, жимсгэнэ” үндэсний хөтөлбөр⁶ (Засгийн газар, №223, 2017). Энэхүү хөтөлбөрийн хүрээнд тус салбарын үйлдвэрлэл эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгжид дараах чиглэлээр дэмжлэг үзүүлэхээр заасан байна. Үүнд:

- жимс, жимсгэнэ тариалах, хураах, хадгалах, боловсруулах үйлдвэр байгуулах, шинэ техник, технологи, инноваци нэвтрүүлэх, шинжлэх ухааны судалгаа, шинжилгээнд санхүү, хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжлэг үзүүлэх;
- чацаргана, бусад төрлийн жимс, жимсгэнийн бүтээгдэхүүнийг экспортлоход учирч байгаа саад тотгорыг арилгах, дотоод зах зээлийг импортын ижил төстэй бараа, бүтээгдэхүүнээс хамгаалах;
- шинээр тариалж, ургуулан үр жимсээ тогтвортой өгч эхэлсэн мод, бутны тоогоор таримлын төрлөөс хамааруулан нэг удаагийн урамшуулал олгох;
- жимс, жимсгэнийн талбайг хашаажуулах, ойн зурвас байгуулах, услалтын систем шинээр байгуулах, орчин үеийн дуслын усалгааны тоног төхөөрөмж суурилуулах,

⁶ <https://www.legalinfo.mn/law/details/12877?lawid=12877>

тариалалт, хөрс боловсруулалт, хураалтыг механикжуулах, суулгац худалдан авах иргэд, аж ахуйн нэгжид санхүүгийн болон хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх;

- жимс, жимсгэнийн тариалалтын талбайг тордон хөрсний үржил шимийг сайжруулах замаар үр өгөөжийг нэмэгдүүлэх, хамгаалалтын ойн зурвас байгуулах, гэр хорооллын өрх хашаанд жимсний мод бут, тэр дундаа чацаргана тариалах иргэдийг дэмжих.

Энэ хөтөлбөр дэх дэмжлэгийг хэрэгжүүлэх асуудалд Засгийн газар, ХХААХҮЯ сүүлийн жилүүдэд нэлээд анхаарал хандуулж ажиллаж эхэлсэн байна. Гэхдээ гадаадын төсөл, хөтөлбөрийн хүрээнд дээрх дэмжлэгийн зарим чиглэлийг дэмжиж ажиллаж байгаа боловч дотоодын эх үүсвэрийн санхүүжилт хомс хэвээр байна.

“Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ыг зарлах тухай Засгийн газрын тогтоол.⁷ Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 476 тоот тогтоолоор тус аяныг 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлүүлж байгаагаа албан ёсоор зарлан баталгаажуулж, энэ аяныг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвөлгөө гаргаж ажиллахыг ХХААХҮЯ-д үүрэг болгожээ.

1.2. Урамшуулал, дэмжлэгийн эрх зүйн орчны шинжилгээ

УИХ-аар 2016 онд батлагдсан **“Тариалангийн тухай”** хуулийн шинэчилсэн найруулгад⁸ газар тариалангийн салбарын хөгжлийг төрөөс дэмжих талаар хэд хэдэн чиглэлийн зохицуулалт орсон байдаг. Үүнд:

Нэгдүгээрт. Тариалангийн бүс нутаг тогтоох талаар

Тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, төрөлжүүлэх, эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэлтэй хослуулан хөгжүүлэх зорилгоор тариалангийн бүс нутгийг аймаг, нийслэлийн ИТХ-ын шийдвэрийг харгалзан ХХААХҮЯ Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэхээр заасан байдаг. Тариалангийн бүс нутагт суурин болон хагас суурийн эрчимжсэн мал аж ахуйг тусгайлсан бэлчээрт эрхлэхээр хуульчилсан байдаг.

Хэрэгжилтийн байдал. Засгийн газрын 2018 оны 131 тоот тогтоолоор Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Цагааннуур, Ерөө, Зүүнбүрэн, Мандал, Орхон, Сант, Баянгол, Сайхан, Жавхлант, Түшиг, Орхонтуул, Баруунбүрэн, Хушаат, Шаамар, Хүдэр сумдын нийт 44 баг; Төв аймгийн Аргалант, Баянхангай, Угтаалцайдам, Цээл, Баянцогт, Баянчандмань, Жаргалант, Сүмбэр, Борнуур, Батсүмбэр, Архуст сумдууд бүхэлдээ, Эрдэнэсант, Заамар сумын 5 баг; Дархан-Уул аймгийн Орхон сум бүхэлдээ, Хонгор сумын 3 баг; Булган аймгийн Хутаг-Өндөр сумын 3 баг; Хэнтий аймгийн Хэрлэн, Жаргалтхаан, Мөрөн, Өмнөдэлгэр, Биндэр, Баян-Адрага, Дадал, Норовлин, Батноров сумдын 16 баг; Өвөрхангай аймгийн Хархорин сумын 3 баг; Архангай аймгийн Цахир, Хангай, Тариат, Чулуут, Өндөр-Улаан, Баянцэнгэл, Ихтамир, Төвшрүүлэх, Булган, Цэнхэр, Хайрхан, Цэцэрлэг, Эрдэнэмандал, Жаргалант, Хашаат, Өлзийт, Өгийнуур, Хотонт сумдын 39 багийг, нийт 7 аймгийн 60 сумын 113 багийг тариалангийн бүс нутгаар баталжээ.

⁷ <https://www.legalinfo.mn/law/details/14938?lawid=14938>

⁸ <https://www.legalinfo.mn/law/details/11641?lawid=11641>

Дээрх тогтоолоор орон нутгийн хөгжлийн бодлого, аймаг, сумын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, төрөлжүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлтэй хослон хөгжүүлэх ажлыг дээр дурдсан аймаг, сум бүр төлөвлөгөөтэй, үе шаттайгаар зохион байгуулах; тариалангийн бүс нутагт мал аж ахуй эрхэлж байгаа малчдын малыг бэлчээр, ус бүхий нутагт шилжүүлэх, мал сүргээ төрөлжүүлэх, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа хийж, бүх талын дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авахыг холбогдох аймгийн төрийн захиргааны байгууллагад хариуцуулжээ. Энэ тогтоолын хэрэгжилт төдийлөн хангалттай бус байгааг бидний ярилцлага хийсэн судлаач, мэргэжилтнүүд тэмдэглэж байв.

Хоёрдугаарт. Тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих чиглэл, санхүүжилтийн талаар

Төрөөс газар тариалангийн үйлдвэрлэлд үзүүлэх дэмжлэгийн хэлбэр, санхүүжүүлэх эх үүсвэр, зориулалт, шалгууртай холбоотой зохицуулалтыг тус хуулийн 19 дүгээр зүйлд тусгасан байдаг. Тухайлбал, тариалангийн үйлдвэрлэлд төрөөс үзүүлэх дэмжлэгийг 1) мөнгөн; болон 2) мөнгөн бус дэмжлэг гэсэн хоёр хэлбэртэй байхаар зааж, дэмжлэгийн хэмжээг Засгийн газар тогтоож байхаар заасан. Тариалангийн үйлдвэрлэлийг төрөөс дэмжин хөгжүүлэх үйл ажиллагааг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлж болно:

- улсын болон орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө;
- тариалангийн салбарт гадаад улс, олон улсын байгууллагаас олгосон зээл, буцалтгүй тусламж;
- гадаад, дотоодын иргэн, хуулийн этгээдээс олгосон хандив, тусламж, хөрөнгө оруулалт.

Дэмжлэгийн хөрөнгийг дараах зориулалтаар зарцуулахаар хуульчилсан байдаг:

- услалтын систем шинээр байгуулах, өргөтгөх, сэргээн засварлах, усан сан, хөв, цөөрөм байгуулах, усалгаатай тариалангийн талбайн хайгуул, судалгаа хийх;
- тариалангийн газрын хөрсний үржил шимийг хамгаалах, сайжруулах, нөхөн сэргээх, бордоо, ургамал хамгааллын бодисын зохистой хэрэглээг төлөвшүүлэх, ойн зурвас байгуулах;
- үр тариа, тэжээл, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний сорт бүтээх, сорих, сортын үр, суулгац үржүүлэх, үйлдвэрлэх болон төмсний бичил булцуу үйлдвэрлэх;
- үр тариа, тэжээл, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний үйлдвэрлэлийн техник, технологийн шинэчлэл хийх, засвар болон техникийн үйлчилгээний төв байгуулах;
- төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний хадгалалт-борлуулалтын тогтолцоог бүрдүүлэх, өвлийн хүлэмж байгуулах;
- үүлэнд зориудаар нөлөөлж хур тунадас оруулах.

Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журмыг ХХААХҮЯ болон Сангийн яам хамтран батална. Мөнгөн урамшуулал олгох, дэмжлэг үзүүлэхэд 1) техник, технологийн шинэчлэл хийсэн; 2) хөрсний үржил шимийн хэвийн байдлыг хадгалсан; 3) ургацын чанарыг тогтвортой дээшлүүлсэн; 4) орон нутгийн иргэдийг ажлын байраар хангасан байдлыг харгалзана гэж шалгуурыг тодорхойлжээ.

Хэрэгжилтийн байдал. Газар тариалангийн салбарыг төрөөс дэмжих хөрөнгийн зориулалтын хувьд услалтын системийг шинээр барих, өргөтгөх, сэргээн засварлах ажлыг 2004 оноос улсын төсвөөс нэлээд эрчимтэй хэрэгжүүлж байснаа сүүлийн жилүүдэд зөвхөн хайгуул, судалгааны ажлыг хариуцан хийх болжээ. Харин АХБ зэрэг донор байгууллагын зээлийн хөрөнгөөр хөрөнгө оруулалтыг дэмжиж байна.

Тариалангийн газрын хөрсний үржил шимийг хамгаалах, нөхөн сэргээхийг дэмжихтэй холбоотой хуулийн заалтын хэрэгжилт сайн биш байна. Зөвхөн бордоогоор дэмжих нь өрөсгөл талтай бөгөөд ээлжлэн тариалалтыг оновчтой хийх замаар энэ асуудлыг шийдвэрлэх боломжтой ч энэ орхигдсон, мөн ашиг тусыг нь хүртэж буй тариаланчдын зүгээс хөрсний үржил шимийг хамгаалах ажилд маш бага анхаардаг ажээ.

Таримал ургамлын сорт, үр үржүүлгийн дэмжлэгийн талаарх хуулийн заалтын хэрэгжилтийн түвшин сул бөгөөд энэ чухал асуудлыг импортоор авах хандлага давамгайлж иржээ. Энд төр-эрдэм шинжилгээ-хувийн хэвшлийн байгууллагуудын түншлэл, хамтын ажиллагаа хангалттай бус байна.

Үр тарианы техник технологийн шинэчлэлийн хувьд 60 орчим хувьтай бөгөөд энэ салбарын үйлдвэрлэл эрхэлдэг компаниудын хөрөнгө санхүүгийн чадавх харьцангуй боломжтой тул цаашид үргэлжлэн хийгдэнэ хэмээн ХХААХҮЯ-ны мэргэжилтнүүд үзэж байна. Харин санхүүгийн чадавх сул төмс, хүнсний ногооны техник, технологийн шинэчлэлд сүүлийн жилүүдэд төрөөс анхаарч дэмжлэг үзүүлж эхэлсэн нь сайшаалтай юм.

“Хүнсний тухай” хуулийн шинэчилсэн найруулга (2012)-д⁹ төрөөс дор дурдсан хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд дэмжлэг, урамшуулал үзүүлэхээр заасан байна:

- стратегийн хүнсний үйлдвэрлэл;
- дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжгүй өргөн хэрэглээний хүнсний импорт;
- үйл ажиллагаандаа зохистой дадал, аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтыг нэвтрүүлсэн;
- Монгол Улсын нутаг дэвсгэрт төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалсан;
- дотоодын түүхий эд ашиглан шинэ технологиор импортыг орлох хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн.

Улаанбуудай нь хүнсний стратегийн хүнсний үйлдвэрлэлд хамрагддаг тул төрөөс уг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгчдэд урамшууллыг үзүүлсээр ирсэн байна. Харин импортыг орлох хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний ногоо, жимсгэний үйлдвэрлэлд үзүүлж буй дэмжлэг төдийлөн хангалттай хэрэгжихгүй байна.

УИХ-аар 2007 онд батлагдсан **“Ургамал хамгааллын тухай”** хуулийн шинэчилсэн найруулгын¹⁰ 16 дугаар зүйлд ургамал хамгааллын үйл ажиллагааны зардлын төрөл, тэдгээрийг санхүүжүүлэх эх үүсвэрийн талаар хуульчилсан байна. Улсын төсвөөс 1) тариалангийн газрын ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамлын байдалд 3 жил тутам судалгаа хийлгүүлж, дүгнэлт гаргуулахад шаардагдах зардлыг; мөн 2) ургамлын хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал тархаж, хөнөөл

⁹ <https://www.legalinfo.mn/law/details/8912>

¹⁰ <https://www.legalinfo.mn/law/details/517?lawid=517>

учруулж болзошгүй үед түүнээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зардлыг тус тус санхүүжүүлэхээр заасан. Тариалангийн газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээд нь дээр дурдснаас бусад ургамал хамгааллын үйл ажиллагааны зардлыг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

Хэрэгжилтийн байдал. Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үзэж байгаагаар, ургамал хамгааллын байдалд 3 жил тутам судалгаа хийлгүүлж, дүгнэлт гаргуулах ажил сүүлийн таван жилд тогтвортой хэрэгжиж байгаа юм байна.

“Үрийн тариалангийн даатгалын тухай” (1999 он) хуульд¹¹ албан журмаар даатгуулах үрийн тариалангийн хүрээ, даатгалын хураамж, нөхөн төлбөртэй холбоотой харилцааг зохицуулдсан байдаг. Энэ хуульд зааснаар тухайн жилд усалгаагүй тариалсан үр тарианы нийт талбайн 20 хувь, усалгаатай тариалсан үр тариа болон баруун бүсийн усалгаагүй тариалсан үр тарианы нийт талбайн 10 хувийг үрийн тариалан гэж үзэж, өмчийн хэлбэр үл харгалзан албан журмаар даатгуулна. Үрийн тариаланг заавал даатгуулах даатгалын хураамж нь даатгалын үнэлгээний 8.0 хувь байх бөгөөд үрийн тариалангийн даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ нь үрийн тариалангийн даатгалын үнэлгээний 80.0 хувьтай тэнцүү байхаар хуульчилсан. Түүнчлэн даатгалын байгууллага нь үрийн тариалангийн албан журмын даатгалаас татгалзах эрхгүй бөгөөд даатгалын эрсдэлийг бүрэн буюу хэсэгчлэн давхар даатгуулж болно гэж заажээ.

Үрийн тариалангийн ган, үер, хүчтэй салхи, шуурга, мөндөр, хяруу, цас, цочир хүйтрэл зэрэг байгалийн эрсдэл; ургамлын гоц хөнөөлт өвчин; хөнөөлт шавж, мэрэгчид; түймэр зэрэг эрсдэлийг албан журмаар даатгах бөгөөд тухайн даатгалын компанид даатгагдсан нийт талбайн 70-аас дээш хувьд тохиолдсоны улмаас даатгагч нь нөхөн төлбөрийг бүрэн нөхөн төлж чадахгүй болсон нь тогтоогдсон нөхцөлд нөхөн төлбөрийн зөрүүг Засгийн газар хариуцна.

Хэрэгжилтийн байдал. Үрийн тариалангийн нийт талбайн 10-20 хувийг албан журмаар даатгуулах тухай дээрх хуулийн заалтын хэрэгжилт хангалтгүй байна. Хэдийгээр хуулинд заавал даатгуулах талаар ийнхүү заасан ч хувийн хэвшлийн тариалан эрхлэгчид даатгуулдаггүй ажээ. Цаашид хуульд өөрчлөлт оруулж, индексжүүлсэн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх боломжтой юм.

“Таримал урамлын үр, сортын тухай” (1999) хуульд¹² үрийн нөөцийн улсын сан байгуулах, түүнийг зарцуулахтай холбоотой харилцааг тусгасан байна. Тухайлбал, байгалийн гамшгийн улмаас тариалах үрээ нөөцөлж чадаагүй үйлдвэрлэгч болон хүнс, тэжээлийн үр тарианы үйлдвэрлэл дагнан эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үр нийлүүлэх, үр шинэчлэх зорилгоор үрийн нөөцийн улсын сан бүрдүүлнэ. Үрийн нөөцийн улсын сан бүрдүүлэх, зарцуулах журмыг Засгийн газар тогтооно. Торгон болон сортын үр үйлдвэрлэх зорилгоор үр үйлдвэрлэгчид агро-цаг уурын тааламжтай нөхцөл бүхий талбай эзэмшүүлэх, үр үржүүлгийн талбайд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэхэд бүх шатны Засаг дарга эрх мэдлийнхээ хүрээнд дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүрэгтэй болохыг хуульчилжээ.

¹¹ <https://www.legalinfo.mn/law/details/14?lawid=14>

¹² <https://www.legalinfo.mn/law/details/471?lawid=471>

“Засгийн газрын тусгай сангийн тухай” хуульд¹³ зааснаар 23 төрлийн тусгай сан байгаагаас Хөдөө аж ахуйг дэмжих сангаас гадна газар тариалангийн үйлдвэрлэлтэй холбоотой байж болох Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Байгаль орчин, уур амьсгалын сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх зориулалтын асуудлыг тусгасан байдаг. Үүнээс Хөдөө аж ахуйг дэмжих сан нь газар тариалан, мал аж ахуй эрхлэх үйл ажиллагааг дэмжих зориулалттай байна. Энэ сангийн хөрөнгийн эх үүсвэрээр газар тариалангийн дараах арга хэмжээг санхүүжүүлнэ:

- 1) хөнгөлөлттэй зээлийг дараах зориулалтаар олгох:
 - усалгаатай тариаланг хөгжүүлэх, усалтын систем байгуулах, сэргээн засварлах;
 - таримал ургамлын үрийн аж ахуйг хөгжүүлэх;
 - хөдөө аж ахуйн техник, технологийн шинэчлэлт хийх.
- 2) тариалангийн газрыг нөхөн сэргээх, хөрсний үржил шимийг сайжруулах;
- 3) тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчээс стандартын шаардлага хангасан буудай худалдан авах, худалдах;
- 4) Хөдөө аж ахуйг дэмжих сангийн үндсэн хөрөнгөд засвар үйлчилгээ хийх;

Хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журмыг Засгийн газар батална.

Хэрэгжилтийн байдал. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын танилцуулгад “Засгийн газрын тусгай сангуудад хийсэн шалгалт, судалгааны үр дүнд зөрчилтэй олон асуудал үүссэн байх бөгөөд тодруулбал, зарим тусгай сангийн ... эх үүсвэрийг зориулалтын бусаар ашигласан, түүнд тавих хяналтын чиг үүргийг хэрэгжүүлээгүй, сангийн хөрөнгийг үндэслэлгүй, хууль бусаар зарцуулсан нийтлэг зөрчил гарсан байна”¹⁴ гэж дурдсан байна.

“Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай” хуулийн шинэчилсэн найруулгад¹⁵ (2019) жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид хамрагдах нөхцөл, төрөөс үзүүлэх дэмжлэгийн чиглэл, нэг удаа олгох зээлийн хэмжээ зэргийг зохицуулсан байна. Энэхүү хуулийн дагуу жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч гэж 200 хүртэл ажилтантай, жилийн 2.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг хамруулан ойлгоно.

Хүснэгт 1. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид хамааруулах аж ахуйн нэгжид тавигдах нөхцөл, нэг удаа олгох зээлийн хэмжээ

№	Аж ахуйн нэгжийн хэв шинж	Ажилтны тоо	Жилийн борлуулалтын орлогын хэмжээ (сая төгрөг)	Нэг удаа олгох зээлийн хэмжээ (сая төгрөг)
1	Бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч	10 хүртэл	300.0 хүртэл	300.0 хүртэл

¹³ <https://www.legalinfo.mn/law/details/14848>

¹⁴ <http://www.iltod.gov.mn/wp-content/uploads/2019/09/06>

¹⁵ <https://www.legalinfo.mn/law/details/14525?lawid=14525>

2	Жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч	10-50	300.0-1000.0	1000.0 хүртэл
3	Дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч	50-200	1000.0-2500.0	2500.0 хүртэл

Эх сурвалж. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн холбогдох заалтыг хүснэгтэд товчоолон харуулав.

Газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн ажиллагчдын тоо цөөн, жилийн борлуулалтын орлогын хэмжээ харьцангуй бага байдаг тул хэрэв тэд бизнесээ компани, хоршоо, нөхөрлөлийн хэлбэрээр эрхэлдэг бол жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид үзүүлэх дэмжлэгт хамрагдах боломжтой юм. Харин энэ хуульд зааснаар таримал ургамлын үр үйлдвэрлэл, ургамал хамгаалахад ашиглах бодисыг импортлох, борлуулах үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж л жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид хамаарахгүй ажээ.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд төрөөс дараах чиглэлийн дэмжлэгийг үзүүлнэ:

- жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, сургах, давтан сургах тогтолцоог хөгжүүлэх;
- санхүүгийн дэмжлэгийг үзүүлэх (хөнгөлөлттэй зээл олгох; шинээр бий болгосон ажлын байрны тоо, борлуулалтын орлогын хэмжээг харгалзан зээлийн хүүгийн хэмжээг бууруулах; зээлийн давхар батлан даалт гаргах; зээлийн хүүгийн татаас олгох; тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ, түрээсийн хүүгийн дэмжлэг үзүүлэх);
- татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх;
- экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих;
- бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтад төрийн худалдан авалтаар дэмжлэг үзүүлэх;
- бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх;
- шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх судалгааг дэмжих;
- техник, технологийн дэвшлийг дамжуулах, нутагшуулах, шинжлэх ухаан, технологийн судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- кластерын хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг тухайн орон нутаг дахь түүхий эдийн болон ажиллах хүчний нөөц, чадавх бусад онцлогоос хамааран дэмжих;
- гадаад, дотоод зах зээлд нэвтрэхэд дэмжлэг үзүүлэх.

Энэ хуулийн хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд дэмжлэг авах боломж нээлттэй байна.

Хэрэгжилтийн байдал. Орон нутагт ажлын байр бий болгох, ядуурлыг бууруулахад нэн чухал ач холбогдолтой жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хөгжлийн хууль эрх зүйн орчин бүрдсэн байна. Гэхдээ энэхүү чухал хуулийн хэрэгжилт санасан түвшинд хүрэхгүй байна. Энэ талаар Монгол банкнаас хийсэн “Жижиг, дунд

үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал” сэдэвт түүвэр судалгаанд¹⁶ “Тэр дундаа нийгэм, улс төрийн орчны зүгээс жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжилд улс төрийн орчин болон хээл хахууль хамгийн гол хүндрэлийг учруулж байна” гэж тэмдэглэжээ. Энэхүү судалгаанд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид авсан зээлээ гол төлөв эргэлтийн хөрөнгө санхүүжүүлэхэд зарцуулдаг, банкны зээлийн нөхцөл харьцангуй хатуу байгааг дурдахын зэрэгцээ цаашид холбогдох төрийн байгууллагуудын үйлчилгээг чирэгдэлгүй нээлттэй байлгах, зээлийн хугацааг уртасгахыг санал болгожээ.

Хувь хүний орлогын албан татварын тухай хууль болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиудын шинэчилсэн найруулга¹⁷ (2019)-д заасны дагуу үр тариа, төмс, хүнсний ногоо, түүний үр, жимс, жимсгэнэ, түүний үр, суулгац, тэжээлийн ургамал тариалж эдгээр бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн Монгол Улсад байнга оршин суугч албан татвар төлөгчийн зөвхөн тухайн үйлдвэрлэлээс олсон орлогод ногдуулах албан татварыг 50 хувиар хөнгөлж байгаа нь төрөөс газар тариалангийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийг дэмжсэн томоохон дэмжлэг мөн. Энэ нь тус салбарын тогтвортой хөгжилд чухал нөлөө үзүүлэх тул цаашид ч уг зохицуулалт хэвээр байх шаардлагатай.

“Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай” хуулийг¹⁸ үе үеийн Засгийн газар гарган хэрэгжүүлж иржээ. Уг хуулиар импортоор оруулж байгаа болон дотооддоо худалдан борлуулсан хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, гурилын болон бордооны үйлдвэрийн тоног төхөөрөмж, усалгааны тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисыг тодорхой хугацааны дотор нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлж, татвараас чөлөөлөгдөх жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-ийн ангиллын дагуу Монгол Улсын Засгийн газар баталдаг. Тухайлбал, 2016 оны 2 дугаар сарын 5 өдөр батлагдсан хуулиар импортоор оруулж байгаа болон дотооддоо худалдан борлуулсан хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбани, машин механизм, гурил болон бордооны үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгаалалын бодисыг 2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрийг хүртэл хугацаанд НӨАТ-аас чөлөөлөх хууль батлагдсан байна.

Хүснэгт 2. Татварын чөлөөлөлтийн дэмжлэг

№	Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт	Хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэлбэр
1	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг 2020 оны 12 сарын 31 өдрийг хүртэл НӨАТ-с чөлөөлөх тухай	НӨАТ-с чөлөөлөх хууль
2	Хөдөө аж ахуйн зориулалттай машин тоног төхөөрөмж, үр бордоо, ургамал хамгааллын бодисыг 2024 оны 12	Гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх тухай хууль

¹⁶ “Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн төлөв байдал” түүвэр судалгааны дүн, Монгол банк, 2018

¹⁷ <https://www.legalinfo.mn/law/details/14410> ба <https://www.legalinfo.mn/law/details/14407>

¹⁸ <https://www.legalinfo.mn/law/details/11644?lawid=11644>

дугаар сарын 31-ий өдрийг хүртэлх хугацаанд Гааль болон НӨАТ-аас чөлөөлөх тухай	
---	--

Энэхүү хуулийн хэрэгжилт, түүний үр нөлөөний талаар хийгдсэн судалгаа хомс байна. Тариаланчидтай фокус ярилцлага хийх үеэр энэ чөлөөлөлтийн ач тусыг тариаланчдаас илүү дундын худалдааны бизнес эрхлэгчид хүртдэг хэмээн шүүмжлэлтэй хандаж байв.

“Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам” (2019, №320)¹⁹ Засгийн газрын тогтоолоор батлагдсан бөгөөд энэхүү журмаар тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсэнд багтах улаан буудайн гурил болон улаан буудайн үрийн хэмжээг эдгээрийн нийт нөөц, эрэлт, нийлүүлэлт, үнийн хэлбэлзэл, хөрш улсуудын зах зээл дэх төлөв байдал, таамаглал зэргийг харгалзан тогтоож байхаар заажээ.

“Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журам”-ыг²⁰ 2019 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд болон Сангийн сайдын хамтарсан 290/А-504 тоот хамтарсан тушаалаар баталжээ. Энэхүү журмыг тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал ба мөнгөн бус дэмжлэг үзүүлэхэд зориулсан хөрөнгийг зарцуулах, тайлагнах, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор батлан гаргажээ. Уг журам анх батлагдсанаас хойш хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт орж, одоо дахин сайжруулалт хийж баталгаажуулахаар ажиллаж байгаа ажээ.

Журмаар дэмжлэг, урамшууллын хөрөнгийн эх үүсвэр, зориулалт, хэлбэр, олгох нөхцөл, шалгуур үзүүлэлт, хүсэлт гаргах, бүрдүүлэх баримт материал, төрийн байгууллагаас үзүүлэх үйлчилгээ, хөрөнгийг зарцуулах, тайлагнах, хяналт тавих харилцааг нарийвчлан тусгажээ.

Тариалангийн тухай хуульд заасан мөнгөн урамшуулал олгох болон дэмжлэг үзүүлэхэд баримтлах шалгуур үзүүлэлтэд заасан техник технологийн шинэчлэл хийх, хөрсний үржил шимийг хамгаалан сайжруулах шалгуурыг энэ журамд бүр нарийвчлан (хөрсний үржил шимийн лабораторын шинжилгээ хийлгэх, хөрсний үржил шимийг сайжруулах арга хэмжээ авсан байх) зааснаас гадна дараах нөхцөл, шалгуурыг нэмж тусгажээ:

- байгаль орчинд ээлтэй, түүний нөөцийг хамгаалах зохистой дэвшилтэт техник, технологи ашиглан нэгжээс авах ургацыг нэмэгдүүлж, тогтвортой үйлдвэрлэл эрхлэх (нөхцөл);
- бүтээгдэхүүнээ зах зээлд хөнгөлөлттэй үнээр нийлүүлж, хангамжийг нэмэгдүүлсэн байх (нөхцөл);
- байгальд ээлтэй ургамал хамгааллын цогц арга, газар тариалангийн зохистой дадал хэрэгжүүлсэн байх (шалгуур);

¹⁹ <https://www.legalinfo.mn/annex/details/10058?lawid=14606>

²⁰ <https://www.legalinfo.mn/annex/details/10497?lawid=14982>

- мэргэжлийн хөдөө аж ахуйн инженер, агроночтой байх (шалгуур);
- тарималын үрийг 5 жил тутамд шинэчилсэн, ..., засвар үйлчилгээний газар байгуулсан эсвэл байгуулах төсөл, хөтөлбөртэй байх (шалгуур);
- тариалан эрхлэлттэй холбоотой холбогдох мэдээллийг харьяалах сумын Засаг даргын тамгын газарт тогтмол гаргаж өгдөг байх (шалгуур).

Журамд стратегийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн гурил үйлдвэрлэх зорилгоор нийлүүлсэн улаан буудайн нэгж хэмжээнд мөнгөн урамшуулал олгох асуудлыг Сайдын шийдвэрээр олгохоор зохицуулсан байна.

Мөнгөн бус дэмжлэг нь дараах төрөлтэй байхаар журамд заасан байна. Үүнд:

- 1) Техник, тоног төхөөрөмжийн дэмжлэг. Үүнийг тухайн техник, тоног төхөөрөмжийн үнэ, хугацаа, төлбөр төлөх нөхцөлийг хөнгөвчлөх замаар зах зээлийн ханшаас хямд үнээр болон зээлээр олгохоор заасан байна.
- 2) Техник, тоног төхөөрөмжөөс өөр төрлийн орцын дэмжлэг. Үүнд жимс, жимсгэний суулгац, үр, бордоо, шатахуун, ургамал хамгааллын бодис, усалгааны тоног төхөөрөмж, услалтын систем, хашаа, ойн зурвас, хөрсний үржил шимийг тодорхойлох шинжилгээ, зоорь, агуулах, хүлэмж, ухаалаг газар тариалан эрхлэхэд шаардлагатай бусад хэрэгсэлийг хамруулжээ.

Урамшуулал, дэмжлэгийг авахын тулд тариалан эрхлэгч хүсэлт, бүтээгдэхүүнээ нийлүүлсэн тухай гэрээ, акт, лабораторийн чанарын шинжилгээний баримт, гэрчилгээ, үнэмлэхийн хуулбар, татварын албаны тодорхойлолт, газар эзэмших, өмчлөх гэрчилгээний хуулбар, шалгуур үзүүлэлтийг хэрхэн хангасан тухай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын болон сумын Засаг даргын тодорхойлолт зэрэг 6 төрлийн бичиг баримт бүрдүүлэхээр журамд заажээ.

Энэ журамд тусгагдсан нэг чухал заалт бол ХХААХҮЯ-ны Хөдөө аж ахуйг дэмжих сан нь мөнгөн урамшуулал болон мөнгөн бус дэмжлэгт зориулан зарцуулсан хөрөнгийн зарцуулалт, санхүүгийн тайлан тэнцэлд дараагийн жилд нь аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулж, Сангийн яамд хүргүүлэхээр заасан асуудал мөн.


Энэхүү журмаар зохицуулсан харилцааг улам боловсронгуй болгохын тулд уг журамд цаашид тусгавал зохих хэд хэдэн асуудал байна. Үүнд:

1. Хөдөө аж ахуйг дэмжих сан хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийг өөрсдөө худалдан авч, дараа нь тариалан эрхлэгчдэд нийлүүлэх аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг практикаас татгалзах шаардлагатай. Тус сан газар тариалангийн үйлдвэрлэлд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн эрэлт хэрэгцээ, нийтлэг шаардлагыг тодорхойлж, тариалан эрхлэгчдээс техник, тоног төхөөрөмжийн захиалга авах чиг үүргийг гүйцэтгэж, харин шаардлагатай санхүүжилтийг арилжааны банкаар дамжуулан шийдвэрлэж байх нь зүйтэй. Тариалан эрхлэгчид өөрсдөө техник, тоног төхөөрөмжөө сонгож олж авах нь зүйтэй юм.
2. Энэхүү тайлан, зөвлөмжид дэвшүүлсэн гол зөвлөмжүүдийг уг журамд тусган хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫГ ДЭМЖИХ ЭДИЙН ЗАСГИЙН ЗАСГИЙН ХӨШҮҮРГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

3.1. Санхүүгийн дэмжлэгийн өнөөгийн байдал

Хөдөө аж ахуй нь дэлхийн хаана ч хүн амыг эрүүл аюулгүй хүнсээр хүртээмжтэй хангах гол эх сурвалж байдаг. Ийм учраас хөдөө аж ахуйн салбартаа дэлхийн улс орнууд гол анхаарал хандуулж, төрийн зүгээс зохих дэмжлэг үзүүлдэг байна. Тухайлбал, Норвеги, БНСУ, Швейцарь, Япон зэрэг улсуудад фермерийн аж ахуйнуудын нийт орлогын 46-65 орчим хувьтай тэнцэх хэмжээний дэмжлэг үзүүлж буйг дараах зургаас харж болно.




Эх сурвалж: *New Estimates of EU Agricultural Support: An “Un-common” Agricultural policy, 2018*

Зураг 2. Фермерүүдэд үзүүлж буй дэмжлэгийн хэмжээ

Монгол Улсын төр засгаас дотоодын хэрэгцээг буудай, төмс, хүнсний ногооны үндэсний үйлдвэрлэлээр хангах зорилгоор анх 1959 онд анхны Атар газар эзэмших аяныг амжилттай хэрэгжүүлснээр газар тариалангийн салбар манай орны эдийн засгийн бие даасан салбар болон хөгжсөн билээ. 2020 оны байдлаар²¹ газар тариалангийн салбарт 1498 аж ахуйн нэгж, 16292 өрх үйлдвэрлэл эрхэлж, нийтдээ 65.0 мянга гаруй тариаланч, механикжуулагч, жимсчид ажиллаж, 706.0 мянга гаруй эргэлтийн талбайд үйл ажиллагаа явуулж байна.

Бусад улсын жишгийн дагуу манай орон ч тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих бие даасан сан байгуулж үйл ажиллагаа явуулж ирсэн байна. Монгол Улсад Буудайн санг анх 1996 онд Канадын буудайн сангийн туршлага дээр тулгуурлан байгуулж байжээ. Улмаар 2006 онд үр тариа, төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, тариалан эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэйгээр Тариалан эрхлэлтийг дэмжих сан байгуулагдсан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 16 дугаар тогтоолоор Тариалан эрхлэлтийг дэмжих санг Мал хамгаалах сантай нэгтгэж Хөдөө аж ахуйг дэмжих сан шинэчилэн зохион байгуулсан байна.



Зураг 3. Үр тариа тариалсан талбай болон ургацын хэмжээ

Монгол Улсын тариалангийн талбайн 70 орчим хувьд улаанбуудай тариалж байгаа бөгөөд газар тариалангийн үйлдвэрлэлийн 75 хувийг энэхүү дэд салбар эзлэж байна. Улаанбуудайг стратегийн бүтээгдэхүүн гэж үздэг. Улаанбуудай нь хүн амын өдөр тутмын өргөн хэрэглээний бүтээгдэхүүн болох гурилын үндсэн орц бөгөөд гурил, гурилан бүтээгдэхүүний үнийг тодорхойлогч онцлог бүтээгдэхүүн юм. Нөгөө талаар, улаанбуудайн үнэ нь инфляцын түвшинд нөлөөлөх гол нэр төрлийн бүтээгдэхүүн мөн.

²¹ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын мэдээлэл, ХХААХҮЯ, 2021 он, хүүд. 35-36

Зураг 3-аас харахад, 1990 оны шилжилтийн эдийн засгийн хүндрэлийн нөлөөгөөр газар тариалангийн салбар уналтад орж, 2006 оныг хүртэл нэн хүнд байдалд байсан бол 2008 онд Атарын III аяны хүрээнд газар тариаланг сэргээж, улаан буудай, төмс, хүнсний ногооны хэрэгцээгээ үндэсний үйлдвэрлэлээр хангах зорилт тавьж, салбарын хөрөнгө оруулалт, дэмжлэгийг нэмэгдүүлсэн нь тариалангийн талбай, нийт ургацын хэмжээнд эерэгээр нөлөөлсөн болох нь харагдаж байна.

Монгол Улсын Их Хурлаас газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг тогтмол үзүүлсээр ирсэн байдаг. Үүнд:

- 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн Монгол Улсын хууль болон Засгийн газрын 2016 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан жагсаалтын хүрээнд импортоор оруулж байгаа болон дотооддоо худалдан борлуулсан хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, гурилын болон бордооны үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, усалгааны тоног төхөөрөмж, ойн аж ахуйн техник, бордоо, ургамал хамгааллын бодисыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, энэ хуулийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд дагаж мөрдөхөөр заасан байдаг.
- 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Монгол Улсын хууль болон Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 335 дугаар тогтоолоор батлагдсан жагсаалтын хүрээнд импортоор оруулж ирж буй 10.0 мянган тонн хүртэлх үрийн улаан буудайг гаалийн албан татвараас чөлөөлөх хууль батлагдаж байсан бөгөөд хуулийг 2018 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл дагаж мөрдөхөөр зохицуулсан байна.
- 2021 оны 02 дугаар сарын 17 өдөр Улсын Их Хурлаар батлагдсан хуулиар хөдөө аж ахуйн зориулалттай машин тоног төхөөрөмж, үр, бордоо, ургамал хамгаалалын бодисыг 2024 он хүртэлх хугацаанд гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөхөөр заажээ.

Хуулийн хэрэгжилтийн үр дүнд газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулан тариаланчид, үйлдвэрлэгчдийн эдийн засгийн чадавхыг сайжруулах, шинэ дэвшилтэт технологи нэвтрэх, байгаль орчинд ээлтэй аргаар газар тариаланг эрхлэх, хөдөлмөр эрхлэлтийг тууштай дэмжин иргэдээ эрүүл, аюулгүй хоол хүнсээр хангах зорилт тавьжээ.

Дэлхийн банкнаас 2012 онд хийсэн судалгаагаар Монгол Улсын хөдөө аж ахуйд олгосон нийт татаасын хэмжээ 93.7 сая ам доллар бөгөөд үүний:

- 44.0 тэрбум төгрөг буюу 36 хувь нь улаанбуудайд;
- 27.0 хувь нь мал аж ахуйд;
- 21.0 хувь нь ноосонд;
- 16.0 хувь нь боловсруулах үйлдвэрт тус тус хувиарлагдсан байна.

Харин 2008–2018 оны хооронд буудайн мөнгөн урамшуулалд нийт 168.0 тэрбум төгрөг зарцуулсан нь жилд дунджаар 15.0 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

Гарцад суурилсан мөнгөн урамшуулал буюу улаанбуудай тариаланчдад олгож буй татаас нь:

- чанарын стандартын шаардлага хангасан (MNS0097:2010) байх;
- дотоодын гурилын үйлдвэр ба улсын нөөцөд нийлүүлсэн тариаланчдад буудайн татаас буюу урамшууллыг буудайн чанараас нь хамааруулан тонн тутамд 50,000-100,000 төгрөгийг урамшуулал хэлбэрээр олгож ирсэн байна.


Энэхүү урамшууллын нэгжийн болон нийт хэмжээний динамикийг дараах хүснэгтээр харуулав.



Эх сурвалж: ХХААХҮЯ-ны мэдээлэл, 2021


Зураг 4. Улаанбуудайн мөнгөн урамшууллын нийт хэмжээ, оноор, тэрбум төгрөг

Улаанбуудайн урамшуулалд 2008-2020 оны хоорондох 12 жилд өссөн дүнгээр нийтдээ 212.0 орчим тэрбум төгрөг зарцуулжээ. Дээрх графикаас харахад, уг урамшууллын жилийн нийт хэмжээ 2008-2011 оны хооронд дунджаар 11.8 тэрбум төгрөг; 2012-2014 онуудад хамгийн өндөр буюу дунджаар 25.7 тэрбум төгрөг; 2015-2017 онуудад хамгийн бага буюу дунджаар 9.3 тэрбум төгрөг; 2018-2020 онуудад дунджаар 20.1 тэрбум төгрөг байна. Урамшууллыг журмын дагуу тушаасан буудайн тонн тутамд нь олгодог тул их хэмжээний ургац авдаг том аж ахуй нэгжүүдэд очих урамшууллын хэмжээ их, харин жижиг аж ахуй нэгжүүдэд оногдож байгаа урамшууллын хэмжээ харьцангуй бага байдаг. Үүнийг зураг 5-д харуулав. Баруун гар талын графикт урамшуулалд олгож байгаа санхүүжилт ба урамшуулал авч байгаа аж ахуй нэгжүүдийг талбайн хэмжээгээр бүлэглэж хувиар илэрхийлсэн бол зүүн гар талын зураг дээрх үзүүлэлтийг тоогоор илэрхийлснийг харуулна.



Зураг 5. Олгосон урамшууллын хэмжээг талбайн хэмжээтэй харьцуулсан харьцаа

Дээрх зургаас харахад, 300 га-аас дээш талбайтай аж ахуй нэгжүүдэд буудайн нийт урамшууллын 66 орчим хувь нь оногдож байна. Өөрөөр хэлбэл, нийт аж ахуйн нэгжүүдийн 5 хувь нь урамшууллын төсвийн 66 хувийг хүртэж байгааг харуулна. Эндээс дүгнэж үзэхэд, улаанбуудай тариалж байгаа аж ахуйн нэгжүүдийн дийлэнх хэсэг нь жижиг дунд аж ахуй нэгжүүд бөгөөд цөөхөн хэдэн том компани тухайн салбарын үйлдвэрлэлд давамгайл байр суурь эзэлж байна гэж үзэж болохоор байна. Иймд цаашид 95 орчим хувийг бүрдүүлж буй жижиг дунд аж ахуй нэгжүүдийг бойжуулах, тэдний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх тал дээр татвар, татаасын бодлогыг явуулах шаардлагатайг харуулж байна.



Эх сурвалж: ХХААХҮЯ, ХААДС, ҮСХ-гийн мэдээллийг үндэслэн тооцов.

Зураг 6. Улаанбуудайн нийт ургацын хэмжээ болон тариаланчдад олгоосон нийт урамшуулал, дэмжлэгийн хэмжээ

Дээрх график буудайн ургац болон урамшууллын өөрчлөлтийн ерөнхий хандлагыг л харуулна. Хураан авсан ургацын хэмжээ болон урамшууллын хэмжээний хооронд логик утгаар шууд хамаарал байх ёстой боловч тухайн жилийн байгаль цаг уурын нөхцөл, буудайн чанар, зах зээлийн болон улсын төсвийн төлөв байдал зэргээс хамаарч уг хамаарал харилцан адилгүй хэлбэрээр илрэн гарах боломжтой.

Монгол Улсын Засгийн газраас дэлхий нийтийг хамарсан цар тахалтай холбогдуулан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-г баталсан. Энэ хүрээнд “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих 500.0 тэрбум төгрөг”-ийн зээлийг олгож эхлээд байна. Уг ажлын хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлд 100.0 тэрбум төгрөгийн зээлийг жилийн 3 хувийн хүүтэй олгохоор тусгасан байдаг. Одоогийн байдлаар уг зээлийг 2165 аж ахуйн нэгж хүсэлт өгч, 30.8 тэрбум төгрөгийн зээл олгогдоод байгаа ажээ.

Тариаланчид болон бодлого боловсруулагчдаас авсан санал асуулгаар ХХААХҮЯ, Хөдөө аж ахуйг дэмжих сан (ХААДС)-гийн зүгээс тоног төхөөрөмжийн хөнгөлөлттэй зээл, орцыг мөн зээлээр өгдөг байдлаас салж, зөвхөн санхүүжилтийн өртөгийг бууруулах буюу зээлийн хүү, хугацааны хөнгөлөлт үзүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь үр дүнтэй болохыг илэрхийлж байна.

3.2. Орцын дэмжлэгийн өнөөгийн байдал

Одоогийн байдлаар тариалан эрхлэгчдэд үйлдвэрлэлийн орц болох техник тоног төхөөрөмж, шатахуун, ургамал хамгааллын бодис, үрийн буудай, бордоо, хүлэмж, үрийн буудай, жимсний суулгац зэрэг нийлүүлэлт нь импортоос хамааралтай орцуудад дэмжлэг үзүүлж байна.

Хөдөө аж ахуйг дэмжих сангаас сүүлийн 6 жилд газар тариалангийн салбарын үйлдвэрлэлийн дараах орцуудын нийлүүлэлтэд дэмжлэг үзүүлж иржээ. Үүнд:

- техник, тоног төхөөрөмжийн зээл;
- шатахууны үнийн дэмжлэг;
- ургамал хамгааллын бодисын дэмжлэг;
- үрийн буудайн дэмжлэг;
- жимс, жимсгэний суулгацын дэмжлэг;
- бордооны дэмжлэг;
- хүлэмжийн аж ахуйн дэмжлэг байна.

Эдгээр дэмжлэгийг эх үүсвэрийн хувьд зээл, улсын төсвийн болон тус сангийн хөрөнгийн дэмжлэг хэлбэрээр иргэн, аж ахуйн нэгжүүдэд олгожээ. ХААДС-гийн мэдээгээр 2015-2020 онд буюу сүүлийн 6 жилд өссөн дүнгээр 243.8 тэрбум төгрөгийн дэмжлэгийг дээр дурдсан зориулалтаар нийт 16.2 мянган иргэн, аж ахуйн нэгжид олгосон байна. Жил бүр дунджаар 40.6 тэрбум төгрөгийн дэмжлэгийг 2.7 мянган иргэн, аж ахуйн нэгжид хүртээсэн байна.

Жил бүр тус сангаас олгож буй дэмжлэгийн хэмжээ харилцан адилгүй тул зөвхөн 2019 оны дэмжлэгийн нийт хэмжээ, бүтцийг авч үзвэл уг онд нийт 39.6 тэрбум төгрөгийн орцын

дэмжлэг үзүүлсэний 5.7 хувийг техник, тоног төхөөрөмжид, 24.5 хувийг шатахуунд, 9.3 хувийг үрийн буудайнд, 8.8 хувийг ургамал хамгааллын бодис, 4.3 хувийг бордоонд, 2.0 хувийг хүлэмжид, 0.4 хувийг жимс, жимсгэний суулгацын зориулалтаар олгожээ. Хүлэмжийн аж ахуйн дэмжлэгийг зөвхөн сүүлийн хоёр жилд үзүүлсэн байна. Үүнээс үзэхэд, орцын дэмжлэгийн дийлэнх хувийг техник, тоног төхөөрөмж болон шатахуун, ургамал хамгааллын бодис эзэлж байна.

ХААДС-гаас олгож буй орцын хөнгөлөлтийн үнийн дүн, тоо хэмжээ болон хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тооны өөрчлөлтийг дараах зургаар харьцуулан харууллаа.




Зураг 7. Орцуудад олгож буй хөнгөлөлт, дэмжлэг

Зураг 7-гоос харахад техник, тоног төхөөрөмжийн үнийн хөнгөлөлтийн дэмжлэгийн нийт хэмжээ сүүлийн хоёр жилийг эс тооцвол ерөнхийдөө нэмэгдэх хандлагатай өөрчлөгдөж иржээ. Ургамал хамгааллын бодис болон шатахууны нийт дэмжлэгийн хувьд ч тийм дүр зураг ажиглагдаж байна. Харин үрийн буудайд үзүүлсэн дэмжлэгийн нийт хэмжээ жил бүр ихээхэн хэлбэлзэлтэй байгаа нь тухайн жилийн ургацын байдал, үрийн

нөөцлөлтөөс хамаарч байгаа нь ойлгомжтой. Жимс, жимсгэний суулгацад уг сангаас бага хэмжээний дэмжлэг үзүүлсэн бөгөөд гол төлөв гадаадын төсөл, хөтөлбөрийн хүрээнд дэмжлэг авсан байна. Ургац болон хөрс хамгаалалд чухал нөлөөтэй бордоонд үзүүлсэн дэмжлэгийн хэмжээ сүүлийн жилүүдэд буурсан нь тийм ч таатай бус өөрчлөлт юм. Энэхүү бууралт нь цар тахлын улбаатай санхүүгийн хүндрэлтэй холбоотой байж болох талтай юм. Шатахууны хөнгөлөлт, үрийн буудай зэрэг орцын хөнгөлөлт зэрэгт хамрагдсан аж ахуй нэгжийн тоо огцом буурсан ч санхүүжилтийн хэмжээ харьцангуй тогтвортой байна. Нөгөө талаар орцуудын зээлийн болон үнийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн хүртээмж бага байгааг илэрхийлж байна.


Орцын нийлүүлэлтийг дэмжих зорилгоор үзүүлж ирсэн дэмжлэгийн өөрчлөлтийн төлөв байдлыг төрөл тус бүр дээр нь нарийвчлан авч үзье. Зураг 8-д иргэн, аж ахуйн нэгжүүдэд техник, тоног төхөөрөмж авахад зориулан олгосон зээлийн дэмжлэгийн нийт хэмжээ болон тариалан эрхэлдэг нийт иргэн, аж ахуйн нэгжүүдийн дүнд уг дэмжлэгт хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн эзлэх хувийн жинг харуулсан байна.



Эх сурвалж: ХААДС, ҮСХ, www.1212.mn-ийн мэдээллийг үндэслэн тооцов.

Зураг 8. Техник, тоног төхөөрөмжид зориулан олгосон хөнгөлөлттэй зээл, түүнд хамрагдсан тариаланчдын эзлэх хувь

Энэхүү зургийн зүүн гар талын багана нь техник, тоног төхөөрөмж худалдан авах хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэн, аж ахуй нэгжүүдийн нийт тариалан эрхлэгч иргэн, аж ахуй нэгжүүдийн дүнд эзлэх хувийн жинг харуулах бөгөөд үүний өөрчлөлтийг тасархай зураасаар харуулав. Энэ үзүүлэлт 2015 онд 8 хувь байсан бол 2020 оны байдлаар ердөө 3 хувьтай байгаа нь нийт тариалан эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжүүдийн 3-хан хувь нь газар тариалангийн техник, тоног төхөөрөмжийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсаныг илэрхийлнэ. Бас нэг тэмдэглэх зүйл бол энэхүү хөнгөлөлттэй зээлд хамрагдагсдын дийлэнх нь үр тарианы үйлдвэрлэл эрхлэгчид байна.




Эх сурвалж: ХААДС, ҮСХ, www.1212.mn-ийн мэдээллийг үндэслэн тооцов.

Тайлбар. Зүүн гар талын багана нь бордоо, ургамал хамгааллын бодисыг хөнгөлөлттэй үнээр худалдан авсан аж ахуй нэгжүүдийн нийт тариалан эрхлэгчдэд эзлэх хувийн жинг харуулах бөгөөд уг үзүүлэлтийн өөрчлөлтийг тасархай зураасаар дүрслэн харуулав.

Зураг 9. Ургамал хамгааллын бодис болон бордоонд зориулан олгосон дэмжлэг, түүнд хамрагдсан тариаланчдын эзлэх хувь

Ургамал хамгааллын бодис болон бордоонд зориулж ХААДС-гаас олгосон дэмжлэгийн хэмжээний өөрчлөлтийг дээрх зургаас харж болно. Нийт тариалан эрхлэгчдийн дүнд хөнгөлөлттэй үнээр ургамал хамгааллын бодис, бордоо худалдан авсан улаан буудайн үйлдвэрлэл эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжийн эзлэх хувийн жин сүүлийн 6 жилийн дунджаар 48 орчим хувьтай байжээ. Харамсалтай нь, энэ үзүүлэлт 2018 оноос хойш буурах хандлагатай байна. Ургамал хамгаалал, бордооны дэмжлэгт өрхийн төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжийн хамрагдалт бага байна.




Эх сурвалж: ХААДС, ҮСХ, www.1212.mn-ийн мэдээллийг үндэслэн тооцов.

Тайлбар. Зүүн гар талын багана нь шатахууныг хөнгөлөлттэй үнээр худалдан авсан аж ахуй нэгжүүдийн нийт тариалан эрхлэгчдэд эзлэх хувийн жинг харуулах бөгөөд уг үзүүлэлтийн өөрчлөлтийг тасархай зураасаар дүрслэн харуулав.

Зураг 10. Шатахуунд зориулан олгосон дэмжлэг, түүнд хамрагдсан тариаланчдын эзлэх хувь

Тариалан эрхлэгчдэд олгож буй шатахууны дэмжлэгийг ХААДС-гаас зөвхөн улаан буудай тариаланчдад олгож байна. Энэхүү дэмжлэгийн нийт дүн болон хүртээмжийн байдлыг Зураг 9-ээр харуулав. 2015-2020 онд өссөн дүнгээр шатахууны хөнгөлөлтийг нийт 6100 иргэн, аж ахуйн нэгжид үзүүлсэн бөгөөд үүнд нийт 51.0 тэрбум төгрөг зарцуулжээ.



Эх сурвалж: ХААДС, УСХ, www.1212.mn-ийн мэдээллийг үндэслэн тооцов.

Тайлбар. Зүүн гар талын багана нь урийн буудайг хөнгөлөлттэй үнээр худалдан авсан аж ахуй нэгжүүдийн нийт тариалан эрхлэгчдэд эзлэх хувийн жинг харуулах бөгөөд уг үзүүлэлтийн өөрчлөлтийг тасархай зураасаар дүрслэн харуулав.

Зураг 11. Урийн буудайд зориулсан дэмжлэг, түүнд хамрагдсан тариаланчдын эзлэх хувь

Урийн буудайн дэмжлэгийг улаанбуудайн тариалан эрхлэгчдэд ХААДС-гаас мөн жил бүр олгож иржээ. Сүүлийн 6 жилийн дүнгээр тус сангаас энэ зориулалтаар 50.0 орчим тэрбум төгрөгийн дэмжлэг зарцуулсан байна. Уг дэмжлэгт улаанбуудайн тариалан эрхлэгчдийн дунджаар 20.8 хувь нь хамрагджээ.

Хөдөө аж ахуйг дэмжих сангаас үзүүлж ирсэн дэмжлэгийн дундаж хэмжээг нэг иргэн, аж ахуйн нэгжид ногдуулан тооцож, дараах хүснэгтээр товчоолон харуулав.

Хүснэгт 3. Нэг иргэн, аж ахуйн нэгжид үзүүлсэн орцын дэмжлэгийн дундаж хэмжээ (сая төгрөг/жил)

Орцын төрөл	2015	2016	2017	2018	2019	2020	Дундаж
Техник, тоног төхөөрөмж	18.1	10.4	54.8	116.7	54	37.7	48.6
Шатахуун	5.9	4.4	9.3	33.7	11.3	7	11.9
Ургамал хамгаалал	6.5	10.6	15.5	10.6	6.7	4.7	9.1

Үрийн буудай	15.8	28.8	22.8	29.7	29.8	32.3	26.5
Жимс, жисгэний суулгац	3.5	7.3	4.3	6.7	6	0.7	4.8
Бордоо	30.1	8.3	23.7	4.8	6.9	4.7	13.1
Хүлэмж					2.6	3.9	3.3
Бусад үр тариа						12	

Эх сурвалж. ХААДС-ийн албан мэдээг үндэслэн тооцов.

Дээрх хүснэгтэд орцын дэмжлэгт хамрагдсан нэг иргэн, аж ахуйн нэгж дунджаар жилд хэдий хэмжээний дэмжлэг хүртсэнийг харуулсан байна. Дэмжлэгт хамрагдсан нэг иргэн, аж ахуйн нэгж дунджаар жилд техник, тоног төхөөрөмжид 48.6 сая төгрөгийн, үрийн буудайнд 26.5 сая төгрөгийн, бордоонд 13.1 сая төгрөгийн, шатахуунд 11.9 сая төгрөгийн, ургамал хамгааллын бодист 9.1 сая төгрөгийн дэмжлэг авчээ.

Хүснэгт 4-ээр улсын хэмжээнд тухайн жилд хураан авсан улаанбуудайн ургацын хэмжээ, буудайн тариалан эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжүүдэд олгосон нийт урамшуулал, дэмжлэгийн дүн, түүнчлэн нэг тоон буудайд хэдий хэмжээний урамшуулал, дэмжлэг ногдож байгаа болон уг бүтээгдэхүүний зах зээлийн үнийн хичнээн хувийг урамшуулал, дэмжлэг эзэлж байгааг тооцож харуулав.

Хүснэгт 4. Нэг тонн улаанбуудайн ногдох урамшуулал, дэмжлэгийн хэмжээ, хувийн эжин

Он	Хураасан нийт улаанбуудайн хэмжээ (мян.тонн)	Иргэн, аж ахуйн нэгждүүдэд олгосон урамшуулал + дэмжлэгийн дүн (тэрбум төгрөг)	Нэг тонн улаан буудайнд ногдох урамшуулал + дэмжлэгийн хэмжээ (төг.)	Нэг тонн улаан буудайн зах зээлийн дундаж үнэ (төг.)	Улаан буудайн нэгжийн үнэд урамшуулал, дэмжлэгийн эзлэх хувь (%)
2015	192904.1	49892.7	258,639.91	560,000.00	46.2
2016	440874.0	48848.6	110,799.45	560,000.00	19.8
2017	215802.2	44269.6	205,139.71	563,333.33	36.4
2018	409071.1	70300	171,852.77	570,000.00	30.1
2019	387168.0	61017.6	157,599.81	580,000.00	27.2
2020	375927.8	57663.3	153,389.31	650,000.00	23.6

Эх сурвалж. ХААДС-ийн албан мэдээг үндэслэн тооцов.

Улаанбуудайн нэгжийн үнэд урамшуулал, дэмжлэгийн эзлэх хувь онуудар харилцан адилгүй байна. Тухайлбал, энэ үзүүлэлт 2015 онд хамгийн өндөр буюу 46.2 хувь байсан бол хамгийн бага нь 2016 онд 19.8 хувь, дунджаар 30.6 хувьтай байна. Өөрөөр хэлбэл, улаанбуудайн зах зээлийн дундаж үнийн 30 гаруй хувьтай тэнцэх урамшуулал, дэмжлэг үзүүлнэ гэдэг бол тариалан эрхлэгчдэд үзүүлж буй том дэмжлэг мөн. Гагцхүү уг дэмжлэгт тариалан эрхлэгчид жигд хамрагдсан эсэх, урамшуулал, дэмжлэг авсан хэмжээгээр тэд ургацаа нэмэгдүүлж чадсан эсэх нь чухал асуудал юм.

Цаашид тариалан эрхлэгчдэд дэмжлэг, урамшуулал үзүүлэхдээ тухайн тариаланчийн өмнөх онуудын ургацын тогтвортой дээшлэлт, чанар, үр ашгийг бодитой

тооцож олгож байвал уг хөшүүргийн үр нөлөө сайн байх болно. Бидний судалгаанд хамрагдсан иргэдийн ярьж байгаагаар үр дүнгийн үзүүлэлтийг гол төлөв цаасан дээр дүгнэж байгааг цаашид засаж сайжруулах шаардлагатай юм.

Төрөөс олгож буй орцын хөнгөлөлт, чөлөөлөлт ургацын хэмжээнд хэрхэн нөлөөлж байгааг хамгийн бага квадратын арга ашиглан регрессийн шинжилгээ хийж, дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 4. Орцын хөнгөлөлтийн ургацад үзүүлсэн нөлөөллийн шинжилгээ


SUMMARY OUTPUT								
Regression Statistics								
Multiple R	1							
R Square	1							
Adjusted R Square	65,535							
Standard Error	-							
Observations	6							
ANOVA								
	df	SS	MS	F	Significance F			
Regression	5	14,771,894.78	2,954,378.96	#NUM!	#NUM!			
Residual	0	-	65,535.00					
Total	5	14,771,894.78						
	Coefficients	Standard Error	t Stat	P-value	Lower 95%	Upper 95%	Lower 95.0%	Upper 95.0%
Intercept	17,282.43	0	65535	#NUM!	17,282.43	17,282.43	17,282.43	17,282.43
Техник тоног төхөөрөмж	(0.50)	0	65535	#NUM!	(0.50)	(0.50)	(0.50)	(0.50)
Шатахуун	(0.60)	0	65535	#NUM!	(0.60)	(0.60)	(0.60)	(0.60)
Ургамал хамгааллын бодис	2.16	0	65535	#NUM!	2.16	2.16	2.16	2.16
Үрийн буудай	(0.30)	0	65535	#NUM!	(0.30)	(0.30)	(0.30)	(0.30)
Бордоо	(3.13)	0	65535	#NUM!	(3.13)	(3.13)	(3.13)	(3.13)

Шинжилгээний үр дүнгээс харахад, ургацын хэмжээнд ургамал хамгааллын бодисын хөнгөлөлт эерэг нөлөөтэй байгаа бол харин бордооны хөнгөлөлт сөрөг нөлөөтэй байна. Харин техник, тоног төхөөрөмж, шатахуун, үрийн буудай зэрэг орцууд буудайн үйлдвэрлэлд мэдэгдэхүйц нөлөөгүй байна. Өөрөөр хэлбэл, газар тариалангийн үйлдвэрлэлийн ургацад орцуудын зээл, үнийн хөнгөлөлт, чөлөөлөлтөөс илүү цаг уур, үйлдвэрлэлийн тариалангийн технологи, хөрс хамгаалал зэрэг бусад хүчин зүйлийн нөлөө ихтэй байдаг ажээ. Тодруулбал, улаанбуудайн га-гийн ургацад нөлөөлж буй хүчин зүйлсийн нөлөөлөл дангаараа (Intercept = 17282.43) тайлбарлагдаж байна.

Тус судалгааны хүрээнд бид бодлого боловсруулагчид, судлаачид, тариаланчдын төлөөллөөс асуулгын аргаар судалгаа авсан бөгөөд уг судалгааны үр дүнгээс танилцуулж байна.

Төрийн зүгээс газар тариалангийн дараах салбаруудын алинд илүү их дэмжлэг үзүүлэх нь зүйтэй вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын дийлэнх нь дэмжих нэн шаардлагатай салбараар хүнсний ногооны үйлдвэрлэл гэж үзсэн бол техникийн ургамлын тариалалтыг дэмжих шаардлагагүй гэж олонх нь сонгосон байна. Харин улаан буудайн үйлдвэрлэлийг дэмжих нэн шаардлагатай гэж 37 хувь нь үзсэн бол 29 хувь нь жимс жимсгэний тариалалтыг дэмжих шаардлагатай гэжээ.


5. Төрийн зүгээс газар тариалангийн дараах асуудлын алинд нь илүү их дэмжлэг үзүүлэх шаардлагатай гэж үзэж байна вэ?



Зураг 12. Дэмжих шаардлагатай салбаруудын байдал

Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, хөнгөлөх дэмжлэгийг импортын дараах барааны алинд нь үзүүлэх нь илүү үр нөлөөтэй гэж үзэж байна вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын хамгийн их буюу 54 хувь нь трактор, комбайн, техник, тоног төхөөрөмж гэж хариулсан бол 29 хувь нь үрийн буудай, 27 хувь нь шатах тослох материал, хамгийн бага буюу 22 хувь нь бордоо, химийн бодис гэж хариулжээ. Энэ нь газар тариалангийн үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт их шаарддаг трактор, комбайн, тоног төхөөрөмжид хөнгөлөлт илүү чухал болохыг харуулна. Гэхдээ энэ нь экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хөрсний үржил шимийг хамгаалах зорилго чиглэлтэй орцуудын дэмжлэгийг үгүйсгэсэн хэрэг бус юм. Нөгөө талаар, эдгээр нь төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний үйлдвэрлэл эрхэлдэг жижиг үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэлд нэн шаардлагатай гол чухал орцууд гэдгийг онцлох нь зүйтэй юм.

6. Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлтийн дэмжлэгийг дараах импортын барааны алинд нь үзүүлэх нь илүү үр нөлөөтэй гэж үзэж байна вэ?




Зураг 13. Татвараар дэмжих шаардлагатай импортын орцуудын байдал

Үнийн хөнгөлөлтийг импортын дор дурдсан барааны алинд нь үзүүлэх нь хэр ач холбогдолтой гэж үзэж байна вэ? гэсэн асуултад асуулгад хариулагчдын 46 хувь нь буюу

хамгийн их нь трактор, комбайн, техник тоног төхөөрөмж хэрэгтэй гэж үзсэн бол 24 хувь нь үрийн буудайнд, 19 хувь нь төмс хүнсний ногоо, жимс, жимсгэний үр, суулгацад, 17 хувь нийлэг хальсан хучлага гэжээ. Харин хамгийн бага хувь нь тэжээлийн таримал ургамлын үрэнд гэж хариулжээ. Эндээс дүгнэж үзэхэд дотооддоо үйлдвэрлэх боломж хязгаарлагдмал, зайлшгүй гаднаас худалдан авдаг орцын импортын татварын хөнгөлөлт тариаланчдад чухал болох нь харагдаж байна. Ер нь олон янзын хөнгөлөлтийг давхардуулан үзүүлэх, эсвэл онцын шаардлагагүй зүйлд дэмжлэг үзүүлэх асуудлыг цаашид цэгцлэх шаардлагатай байна.


7. Үнийн хөнгөлөлтийг импортын дор дурдсан барааны алинд нь үзүүлэх нь хэр ач холбогдолтой гэж үзэж байна вэ?



Зураг 14. Үнийн хөнгөлөлтөөр дэмжих шаардлагатай орцуудын байдал

Зээлийн хөнгөлөлтийг дор дурдсан үйл ажиллагааны алинд нь үзүүлэх нь хэр ач холбогдолтой гэж үзэж байна вэ? гэсэн асуултад мөн л судалгаанд оролцогчдын олонх буюу 44 хувь нь трактор, комбайн, техник хэрэгсэл худалдан авах нь илүү ач холбогдолтой гэж хариулсан бол 33 хувь нь үр худалдан авах, 30 хувь нь эргэлтийн хөрөнгө санхүүжүүлэхэд, 27 хувь нь шатахуун худалдан авахад уг хөнгөлөлтийг зориулах нь зүйтэй гэж хариулжээ.

8. Зээлийн хөнгөлөлтийг дор дурдсан үйл ажиллагааны алинд нь үзүүлэх нь хэр ач холбогдолтой гэж үзэж байна вэ?




Зураг 15. Зээлийн хөнгөлөлтөөр дэмжих шаардлагатай орцуудын байдал

Улаан буудайн урамшууллыг тариалан эрхлэгч этгээдийн алинд нь олгох нь илүү үр дүнтэй гэж үзэж байна вэ? гэсэн асуултад хариулсан хүмүүсийн бараг бүгд уг урамшууллыг аж ахуй нэгжийн хэмжээгээр юмуу хуулийн этгээдийн хэлбэрээр нь ялгахгүйгээр бүгдэд нь үзүүлэх нь зүйтэй гэж хариулсан байна. Өөрөөр хэлбэл, урамшуулал нь буудайн үнийн зөрүү тул том, жижиг эсвэл аж ахуйн нэгж, иргэн гэж ялгах нь буруу гэж дийлэнх тариаланчид ярьж байлаа.

Улаан буудайн урамшууллыг олгохдоо дараах шалгуур үзүүлэлтүүдээс алиныг нь гол шалгуур болгох нь чухал вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 48 хувь нь гурилын үйлдвэрүүдэд чанартай буудай нийлүүлдэг байх нь чухал гэж хариулжээ.

9. Улаанбуудайн урамшууллыг газар тариалан эрхлэгч дараах этгээдийн алинд нь олгох нь илүү үр дүнтэй гэж үзэж байна вэ?



Зураг 16. Зээлийн хөнгөлөлтөөр дэмжих шаардлагатай орцуудын байдал

Өөрөөр хэлбэл, өнөөдөр хэрэглэж буй гол шалгуурыг зүйтэй гэж үзэж байгаа ажээ. Харин 37 хувь нь байгальд ээлтэй технологи хэрэглэдэг аж ахуйн нэгжүүдэд урамшуулал олгох гол шалгуур болгох ёстой гэж үзсэн бол 30 орчим хувь нь ажлын байрыг хадгалж үлддэг аж ахуйн нэгжүүдийг дэмжих үүднээс урамшуулалын гол олгох үндсэн шалгуур байх нь зөв гэж үзжээ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨШҮҮРГИЙГ САЙЖРУУЛАХ БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ, ҮР ДҮН

4.1. Хөдөө аж ахуйн хөгжлийг дэмжих сангийн үйл ажиллагааны талаар

Тус сангийн үйл ажиллагааг боловсронгуй болгон сайжруулахын тулд: (i) үйл ажиллагааг нь цахимжуулж, ухаалаг технологи нэтрүүлэх замаар нийтэд ижил тэгш мэдээлэл хүргэх боломж олгохуйц илүү нээлттэй, ил тод байдлыг хангах; (ii) аж ахуйн шинжтэй үйл ажиллагаа эрхлэхээс аль болох татгалзаж, оновчтой бодлого, дүрэм, журмын дагуу харилцагчдыг шаардлагатай мэдээллээр хангах, төлөвлөлт, зохицуулалтын шинжтэй чиг үүргээ хэрэгжүүлэхэд гол анхаарлаа төвлөрүүлэх; (iii) шийдвэр гаргалтын шуурхай байдлыг хангаж, үр, бордоо, шатахуун зэрэг орцын нийлүүлэлтийг технологийн цаг хугацаанд нь хийхэд анхаарах; “Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журам”-ыг шинэчилэн батлахдаа энэхүү тайлан, зөвлөмжид дэвшүүлсэн гол санааг тусган хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

4.2. Улаанбуудайн урамшууллын талаар өгөх бодлогын зөвлөмж

Улаан буудайн үйлдвэрлэлд төрөөс нэг талаар урамшуулал өгөөд нөгөө талаас улаанбуудайн үнийн дээд түвшнийг (таазыг) тогтоож байгаа нь тариаланчдад тийм ч таатай бус байна. Үүний хэд хэдэн үндэслэл байна. 1) Энэ сэдвээр тэдэнтэй фокус ярилцлага хийж үзэхэд, тэдний дийлэнх нь улаан буудайн үнийг чөлөөлж, зах зээлийн зарчмаар ажиллах нь зүйтэй гэж үзэж байв. 2) Тариалан эрхлэгчид үйлдвэрлэлдээ хэрэглэх машин техник, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, шатахуун, бордоо, гербицид, үр зэрэг дийлэнх орцыг импортоор авдаг бөгөөд тэдгээрийн үнэ тогтмол өсөх хандлагатай байхад улаанбуудайн зах зээлийн үнэ төдийлөн өсөхгүй байна. Энэ нь уг бүтээгдэхүүний үнийг төрөөс хянаж байгаатай холбоотой юм. 3) Улаанбуудайн гол хэрэглэгч дотоодын үндсэн гурван үйлдвэр байдаг бөгөөд тэд зах зээлийн хэв шинжийн хувьд олигопсон шинжтэй тул улаанбуудайн үнэд зохих хэмжээгээр хяналт тавих боломжтой нь тус бүтээгдэхүүний үнийн өсөлтийг хязгаарлах нэг хүчин зүйл болдог. Тариаланчдаас гурилын үйлдвэрт тушаасан улаанбуудайн чанарыг гурилын үйлдвэрүүдийн дэргэдэх лабораториор шалгаж зэрэглэл тогтоодог тул түүнд тариаланчид итгэдэггүй байна. 4) Жил бүрийн намар ургац хураалтын дараа улаанбуудайн үнийг тогтоох асуудлаар Засгийн газар, тариаланчид болон гурил үйлдвэрлэгчдийн дунд зохих хэмжээний зөрчил, маргаан өрнөдөг бөгөөд уг шийдвэр нь зах зээлийн зарчимд нийцдэггүй тул аль нэг тал нь хохиролтой үлддэг. 5) Улаанбуудайн үнийг чөлөөлсөн нөхцөлд тариаланчид уг бүтээгдэхүүний зах зээлийн үнийн бууралтын эрсдэлийг өөрсдөө хариуцаж, зах зээлийн зарчмаар ажиллах боломжтой.

Тариаланчдаас гурилын үйлдвэрт тушаасан улаан буудайн тонн тутамд тооцож төрөөс олгож буй урамшууллын эдийн засгийн утга нь татвар төлөгчдөөс үйлдвэрлэгчдэд өгч буй шилжүүлэг буюу зах зээлийн үнийн дэмжлэг мөн. Энэхүү дэмжлэг нь эдийн

засгийн хувьд үр ашигтай байх ёстой. Энэ талаар доктор П.Эрдэнэбат “Дэмжлэгийг зохистой байдлын үр дүн ба үр ашгийг үндэслэн тодорхойлж байвал зохино”²² гэсэн санал нэгтэй байна.

Урамшууллыг улаанбуудайн чанараар ялгавартай өгч байгаа нь зөв боловч чанарын зэрэглэл хоорондын урамшууллын зөрүү 20.0 мянган төгрөг байгааг ахиулах юм бол чанарын хөшүүргийн үр нөлөө сайжирна.

Холбогдох хууль, журмаар улаанбуудайн урамшуулал олгох нэг гол шалгуур болох хөрсний үржил шимийг доройтуулаагүй байх шалгуур нь зөв зүйтэй боловч уг шалгуурын хэрэгжилтийг хянаж үнэлэх асуудал хүндрэлтэй байна. Иймд тариаланчид өөрсдийн эзэмшил, ашиглалтад байгаа газрын хөрсний үржил шимийн байдалд 5 жил тутам мэргэжлийн байгууллагаар судалгаа хийлгүүлэн үнэлгээ өгүүлж, уг үнэлгээг шалгуурын үндэслэл болгох нь зүйтэй байна.

Улаанбуудайн болон бусад таримал ургамалд төрөөс урамшуулал үзүүлэхдээ хөрс хамгаалалтын арга хэмжээг сайн хийсэн, үйлдвэрлэлдээ байгальд ээлтэй технологи нэвтрүүлсэн, тариалангаа даатгуулсан, ялангуяа үрийн тариалангийн даатгалд хамрагдсан байдлыг гол шалгуур үзүүлэлт болгох нь чухал ач холбогдолтой байна.

Гурилын үйлдвэрүүдэд тушаах улаанбуудайн чанарын зэрэглэлийг ашиг сонирхлын зөрчлөөс ангид хөндлөнгийн лабораториор тогтоолгож байх нь зүйтэй байна.

Улаанбуудайг биржийн тогтолцоонд холбох нөхцөлийг бүрдүүлж, зах зээлийн өрсөлдөөнөөр үнэ тогтох боломж бүрдүүлбэл буудайн чанарт ахиц дэвшил гарахын зэрэгцээ тариаланчид, гурил үйлвэрлэгчид хоорондоо үр ашигтай хэлцэл хийх боломжтой.

Иймд улаанбуудай үйлдвэрлэгчдэд олгож буй урамшууллаас үе шаттайгаар татгалзаж, улаанбуудайн чөлөөт зах зээлийн харилцаанд оруулах нь зүйтэй байна. Улаанбуудайн урамшууллаас чөлөөлөгдсөн хөрөнгийн эх үүсвэрийг хөрс хамгаалах, үйлдвэрлэлд дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд зориулж зарцуулах нь илүү үр дүнтэй байх болно.

4.3. Үнийн, зээлийн болон татварын чөлөөлөлт, хөнгөлөлтийн хөшүүргийн талаар өгөх бодлогын зөвлөмж

Зээлийн болон үнийн хөнгөлөлтийг дараах чиглэлээр түлхүү үзүүлэх нь зүйтэй байна. **Хөрс хамгаалал.** Тариаланчдын өмнө тулгамдаж буй хамгийн гол асуудлын нэг нь тариалангийн газрын хөрсний үржил шим буурч байгаа явдал мөн. Үндэслэл нь: 1) Тариалангийн газар төрийн өмч бөгөөд эзэмшин ашиглагчид нь хөрсний үржил шимийг хамгаалахад онцгой ач холбогдол өгөхгүй байна. 2) Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн чадавх нь сул учраас тухайн жилийн урсгал зардалд хөрөнгөө зарцуулж, хөрс хамгаалах зэрэг урт хугацааны ач холбогдолтой асуудалд хөрөнгө нь хүрэлцэхгүй байна. 3) Тариаланчид хөрс хамгаалахыг дэмжихэд чиглэгдсэн үнийн болон

²² П.Эрдэнэбат “Буудай тариалдаг аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэлийн үр ашгийн шинжилгээ” сэдэвт диссертаци, Улаанбаатар, 2021 он, хууд. 88

зээлийн хөнгөлөлт нь үйлдвэрлэлийг дэмжих урамшууллаас илүү ач тустай хэмээн үздэг байна.

Үүнтэй холбоотойгоор хөрс хамгаалахад чиглэгдсэн шинэ технологи, инноваци нэвтрүүлэх, байгальд ээлтэй бордоо хэрэглэхийг хөнгөлөлттэй ногоон зээлээр нэн тэргүүнд дэмжих шаардлагатай байна. Үүнд зөвхөн Хөдөө аж ахуйг дэмжих сан бус дотоод, гадаадын санхүүжилтийн бусад боломжит эх үүсвэрийг ашиглах шаардлагатай.

Тариалангийн газрын хашаажуулалт, ойн зурвас. Тариалангийн бүс тогтоосноор мал аж ахуй болон газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн зөрчил үндсэндээ шийдвэрлэгдээгүй байна. 1) Тариаланчдын үзэж байгаагаар тариалангийн бүс тогтоосон Засгийн газрын тогтоолын хэрэгжилт практик дээр хэрэгжилт нь хангалттай бус байна. 2) Тариалангийн газарт мал орж, ургацыг сүйтгэж, тариаланчид, малчдын хоорондын зөрчилдөөн үргэлжилсээр байгаа ажээ.

Иймд хөнгөлөлттэй зээлээр дэмжих нэг тэргүүлэх чиглэл бол үр тарианы томоохон талбайг хашиж хамгаалах, ойн зурвас байгуулахад шаадлагатай хөрөнгөд хөнгөлөлттэй зээл олгох явдал мөн.

Техникийн нийлүүлэлт. Хөдөө аж ахуйн хөгжлийг дэмжих сангаас тариаланчдад урьдчилан зээлээр олгож, дараа төлөх нөхцөлтэй трактор, комбайн, тоног төхөрөмжийн нийлүүлэлтийн үнийн болон чанарын асуудалд тариаланчид сэтгэл дундуур байна. Учир нь уг сангаар дамжуулан авсан техникийн үнэ нь зах зээлийн үнээс өндөр байхаас гадна бас хүссэн маркийн техник орж ирдэггүй гэсэн үндэслэл хэлж байв. Үйлдвэрлэлдээ тохирсон машин техник, тоног төхөөрөмжөө өөрсдөө худалдан авах сонголтыг тариаланчдад үлдээх нь зүйтэй юм.

Ер нь улсын төсвийн хөрөнгөөр техник худалдаж авахаас салж, харин зээлийн хүүний хөнгөлөлт, зээлийн барьцаа хөрөнгөд дэмжлэг үзүүлэх нь чухал юм.

Иймд Хөдөө аж ахуйг дэмжих сан нь шаардлагатай хөдөө аж ахуйн машин техникийн эрэлт хэрэгцээг төлөвлөх, тавигдах эдийн засгийн болон техник, технологийн нийтлэг шаардалага, журмыг тогтоох асуудлыг хариуцаж, харин уг техникийг авахад шаадлагатай зээлийг банкаар дамжуулан тариаланчдад олгож, тэд өөрсдөө зах зээлээс олж авах нь чухал байна.

Бусад төрлийн хөнгөлөлт, дэмжлэгтэй харьцуулахад зээлийн хөнгөлөлт нь хөндлөнгийн явцуу эрх ашгийн нөлөөгүй тул илүү шударгаар олгогддог хэмээн тариаланчид үздэг байна.

Импортын барааны татварын хөнгөлөлт. Монгол Улсын Хувь хүний орлогын албан татвар болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн дагуу татвар төлөгч үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, тэжээлийн ургамал тариалж, эдгээр үйлдвэрлэлээс олсон орлогод ногдуулах албан татварыг 50 хувиар хөнгөлж байгаад тариаланчид сэтгэл ханамжтай байна. Иймд энэ хөнгөлөлтийг хэвээр нь үргэлжлүүлэх нь зүйтэй байна.

Харин эрэлт хэрэгцээ нь улирлын шинжтэй шатахуун, үр, бордоо зэрэг тариалангийн үйлдвэрлэлийн импортын орцын нийлүүлэлтэд үзүүлж буй нэмэгдсэн өртгийн албан татварын болон гаалийн татварын хөнгөлөлтийн үр нөлөө, ач тусыг тариалан эрхлэгчид төдийлөн мэдрээгүй байсан бөгөөд тэд уг хөнгөлөлтийн ач тусыг эдгээр барааг импортолдог дундын худалдаа бизнес эрхлэгчид хүртдэг гэж үзэж байв. Иймд энэ төрлийн татварын хөнгөлөлт шаардлагагүй байж болох талтай юм.

Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний үйлдвэрлэл эрхлэгчдэд төрөөс үзүүлж буй дэмжлэг, хөнгөлөлт бага байна. Эдгээр бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгчдийн дийлэнх нь албан бус хөдөлмөр эрхлэлтийн статустай, нэгдсэн албан ёсны бүртгэл дутмаг тул дэмжлэгт хамрагдалгүй үлддэг байна. Үйлдвэрлэлдээ хяналтгүйгээр пестицид, химийн бодис ихээр хэрэглэж байгаа тул ногоочдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал анхаарлын гадна хаягдсаныг мэргэжилтнүүд санаа зовж ярьж байв. Тэд олсон орлогоо буцаагаад эмчилгээнд зарцуулдаг байна.

Иймд импортын хамааралтай хүнсний ногоо, жимс жимсгэний үйлдвэрлэл эрхлэгчдийг бүтээгдэхүүнээ нийлүүлэх борлуулалтын нэгдсэн системд холбож, цахим бүртгэлд хамруулж байж, үзүүлэх дэмжлэгээ нэмэгдүүлэх шаардлагатай.

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Асуулгын хуудас

САНАЛ АСУУЛГЫН ХУУДАС

Герман-Монголын “Тогтвортой хөдөө аж ахуй” төслийн хүрээнд Газар тариалангийн салбарын хөгжлийг төрөөс татвар, татаас, урамшуулал, үнийн хөнгөлөлт, зээл зэрэг эдийн засгийн хөшүүргээр дамжуулан үзүүлэх дэмжлэгийн талаар тойм судалгаа хийж, зөвлөмж боловсруулах зорилгоор энэхүү санал асуулгыг авч байна. Та дараах асуултад хариулж, энэхүү чухал асуудалд хувь нэмрээ оруулна уу.

Асуулгад хариулагчийн ерөнхий мэдээлэл:

Асуулгад хариулагчийн нэр:

Ажилладаг байгууллага:

Эрхэлдэг ажил:

Оршин суудаг аймаг (хот), сум (дүүрэг):

Дараах асуулт бүрийн сонголттой хариултаас өөрийн дэмжиж буй зөвхөн нэгийг нь сонгож урд талын гурвалжин дотор дарж хариулна уу.

1. Газар тариалангийн хөгжлийг төрийн зүгээс эдийн засгийн хөшүүргээр хэрхэн дэмжиж ирсэн талаар Та өмнө нь мэддэг байсан уу?

- A. Сайн мэддэг
- B. Сонсож байсан
- C. Мэддэггүй

2. Ер нь газар тариалангийн хөгжлийг төрийн зүгээс эдийн засгийн хөшүүргээр дэмжих шаардлагатай гэж үзэж байна уу?

- A. Зайлшгүй шаардлагатай
- B. Шаардлагатай
- C. Шаардлагагүй

3. Шаардлагатай гэж үзэж байгаа бол гол үндэслэл нь юу вэ?

- A. Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх нь их эрсдэлтэй
- B. Газар тариалан үйлдвэрлэл эрхлэх нь их хөрөнгө санхүү шаарддаг
- C. Энэ салбар хүн амыг хүнсээр хангахад чухал ач холбогдолтой
- D. Уг салбар нь ажиллах хүч их шаарддаг тул ажилгүйдлийг бууруулахад онцгой үүрэгтэй

Та 4-9 дүгээр асуултад хариулахдаа сонголттой хариултуудын ач холбогдолынх нь эрэмбийг харгалзан хамгийн их ач холбогдолтой бол 5, ач холбогдолтой бол 4, ач холбогдол нь дунд зэрэг бол 3, ач холбогдол багатай бол 2, ач холбогдолгүй бол 1 гэсэн тооны аль нэгэнд тохирох харгалзах дугуйг бөглөж хариулна уу.

4. Төрийн зүгээс газар тариалангийн аль дэд салбарын хөгжлийг илүү их дэмжих нь чухал гэж үзэж байна вэ?

<i>Хариулт</i>	<i>Хариултын ач холбогдлын эрэмбэ</i>				
	<i>1 – Огт чухал биш</i>	<i>2- Нэг их чухал биш</i>	<i>3 – Дунд зэрэг</i>	<i>4 – Их чухал</i>	<i>5 – Нэн их чухал</i>
А) Улаан буудайн үйлдвэрлэл					
В) Төмсний үйлдэрлэл					
С) Хүнсний ногооны үйлдвэрлэл					
Д) Малын таримал тэжээлийн үйлдвэрлэл					
Е) Жимс, жимсгэний үйлдвэрлэл					
Ү) Техникийн ургамал					

5. Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлтийн дэмжлэгийг дараах импортын барааны алинд нь үзүүлэх нь илүү үр нөлөөтэй гэж үзэж байна вэ?

<i>Хариулт</i>	<i>Хариултын ач холбогдлын эрэмбэ</i>				
	<i>1 – Нөлөөгүй</i>	<i>2- Нэг их нөөцтэй биш</i>	<i>3 – Дунд зэрэг</i>	<i>4 – Их нөлөөтэй</i>	<i>5 – Нэн их нөлөөтэй</i>
А) Шатах тослох материалд					
В) Бордоо, химийн бодист					
С) Трактор, комбайн, техник хэрэгсэлд					
Д) Улаан буудайн үрэнд					

6. Үнийн хөнгөлөлтийг импортын дор дурдсан барааны алинд нь үзүүлэх нь хэр ач холбогдолтой гэж үзэж байна вэ?

<i>Хариулт</i>	<i>Хариултын ач холбогдлын эрэмбэ</i>				
	<i>1 – Огт ач холбогдолгүй</i>	<i>2- Нэг их ач холбогдолтой биш</i>	<i>3 – Дунд зэрэг</i>	<i>4 – Их ач холбогдолтой</i>	<i>5 – Нэн их ач холбогдолтой</i>
А) Үрийн буудайнд					
В) Тэжээлийн таримал ургамлын үрэнд					
С) Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний үр, үрсэгт					
Д) Нийлэг хальсан хучлагад					
Е) Трактор, комбайн, техник хэрэгсэлд					

7. Зээлийн хөнгөлөлтийг дор дурдсан үйл ажиллагааны алинд нь үзүүлэх нь хэр ач холбогдолтой гэж үзэж байна вэ??

<i>Хариулт</i>	<i>Хариултын ач холбогдлын эрэмбэ</i>				
	<i>1 – Огт ач холбогдолгүй</i>	<i>2- Нэг их ач холбогдолтой биш</i>	<i>3 – Дунд зэрэг</i>	<i>4 – Их ач холбогдолтой</i>	<i>5 – Нэн их ач холбогдолтой</i>
А) Трактор, комбайн, техник худалдан авахад					
В) Эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлэхэд					
С) Шатахуун худалдан авахад					
Д) Үр худалдан авахад					

8. Улаанбуудайн урамшууллыг газар тариалан эрхлэгч дараах этгээдийн алинд нь олгох нь илүү үр дүнтэй гэж үзэж байна вэ?

<i>Хариулт</i>	<i>Хариултын ач холбогдлын эрэмбэ</i>				
	<i>1 – Огт үр дүнгүй</i>	<i>2- Нэг их үр дүнтэй биш</i>	<i>3 – Дунд зэрэг</i>	<i>4 – Их үр дүнтэй</i>	<i>5 – Нэн их үр дүнтэй</i>
А) Том аж ахуйн нэгжид					
В) Жижиг, дунд аж ахуйн нэгжид					
С) Иргэдэд					
Д) Бүгдээрэнд нь					

9. Улаанбуудайн урамшууллыг олгохдоо дараах шалгуур үзүүлэлтүүдээс алиныг нь гол шалгуур болгох нь чухал вэ?

<i>Хариулт</i>	<i>Хариултын ач холбогдлын эрэмбэ</i>				
	<i>1 – Огт чухал биш</i>	<i>2- Нэг их чухал биш</i>	<i>3 – Дунд зэрэг</i>	<i>4 – Их чухал</i>	<i>5 – Нэн их чухал</i>
А) Тогтвортой өндөр ургац авдаг					
В) Үйлдвэрлэлдээ байгальд ээлтэй технологи хэрэглэдэг					
С) Буудайгаа биржээр дамжуулан зах зээлд нийлүүлдэг					
Д) Тариаланчдын ажлын байрыг тогтвортой хадгалж нэмэгдүүлсэн					
Е) Гурилын үйлдвэрүүдэд чанартай буудай нийлүүлдэг					

10. Газар тариалангийн хөгжлийг дэмжих төрийн бодлогын эдийн засгийн хөшүүргийг илүү үр ашигтай болгох талаарх Таны санаа бодол (бичих):

.....

.....

.....

.....

Цаг заваа гаргаж асуултуудад үнэн бодитой хариулсан Танд талархал илэрхийлье!

“Тогтвортой хөлөө аж ахуй” төсөл
ХХААХҮЯ

Хавсралт 2. Асуулгын судалгаанд оролцогчид

№	Асуулгад хариулагчийн нэр	Ажилладаг байгууллага	Эрхэлдэг ажил	Оршин суудаг аймаг (хот)
1	Б.Эрдэнэболор	Тогтвортой ХАА төсөл	Мэргэжилтэн	Улаанбаатар
2	П.Буяннэмэх	ХААИС	Багш, судлаач	Улаанбаатар, СХД
3	Ундрах-Од	МТҮХ	Захирал	Улаанбаатар
4	Энх-Амар	Өргөө хайрхан ХХК	Ногоо тариалагч	Улаанбаатар, СХД
5	Энх-Амгалан	Болжим Цайдам ХХК	Менежер	Сэлэнгэ, Сайхан
6	Чойжилсүрэн	Дархантооромт ХХК	Агрономич	Дархан-Уул, Хонгор
7	Д.Мягмарсүрэн	ХААИС	Тэнхимийн эрхлэгч	УБ, ХУД
8	И.Батхишиг	ХААИС	Тэнхимийн эрхлэгч	Дархан-Уул, Дархан
9	Т.Хишигбуян	ХААИС	Багш	Дархан-уул
10	Ц.Сансаргэрэл	ХААИС	Багш	Дархан-Уул, Дархан
11	Балдангомбо	Тариаланч	Тариаланч	Сэлэнгэ
12	Доржоо	ХААИС	Багш	Хан-Уул
13	Д.Хишигсүрэн	УГТХ	Секторын эрхлэгч	Дархан-Уул
14	Сүнжидмаа	УГТХ	Лаб. эрхлэгч	Дархан-Уул
15	Азаяа	УГТХ	ЭШДА	Дархан
16	П. Гэрэлтуяа	УГТХ	ЭША	Дархан-Уул, Дархан
17	Б.Саранчимэг	УГТХ	ЭША	Дархан-Уул, Дархан
18	Байгалмаа	УГТХ	Секторын эрхлэгч	Дархан-Уул
19	Цэрэнчимэд	Гарааны Био Ундарга	Захирал	Дархан Уул, Дархан
20	Гэрэлзаяа	ХХААХҮЯ	Хэлтсийн дарга	УБ. ХУД
21	Баярсүх	УГТХ	ЭША	Дархан-Уул, Дархан
22	Ч.Чадраабал	Ариун хур ХХК	Бизнесмен	Сэлэнгэ, Цагаануур
23	Бямбацэрэн	Өгөөж мандал ХХК	Захирал	Улаанбаатар
24	Э.Дэлгэрцэцэг	Бүрэнбургалтай ХХК	Менежир	Сэлэнгэ, Орхон
25	Ундрах	Нью Ариг Ус ХХК	Ня-бо	УБ хот БЗД
26	Батбаяр	Хос түрүү ХХК	Захирал	Улаанбаатар, СБД
27	Саранцэцэг	Баян-Ундрага ХХК	Захирал	Сэлэнгэ, Алтанбулаг

28	Ундрах	Усжуулах ХХК	Захирал	Увс, Баруунтуруун
29	Цандэлэг	Урга-Хүдэр ХХК	Менежер	Сэлэнгэ Хүдэр
30	Отгонбаяр	Налгар тариалан ХХК	Захирал	Дархан-Уул, Дархан
31	Донжжалам	Одон буудай ХХК	Захирал	Сэлэнгэ Зүүнбүрэн
32	Чулуун	Гэгээлэг трейд ХХК	Захирал	Сэлэнгэ, Зүүнбүрэн
33	Мягмарсүрэн	Жи Эн ЭФ ХХК	Захирал	Өвөрхангай, Хархорин
34	Баттүвшин	Соёмбо түрүү ХХК	Захирал	Төв, Эрдэнэсант
35	Ш.Хандсүрэн	Алтант тошлой ХХК	Захирал	Орхон, Жаргалант
36	Д.Нямгэрэл	Эрдэнэ виллиямс ХХК	Захирал	Архангай, Өлзийт
37	С.Ганболд	"Их шинстэй" ХХК	Захирал	Сэлэнгэ, Ерөө
38	Х.Даваахүү	"Түмэн бут" ХХК	Захирал	Сэлэнэ, Баянгол
39	Энхболд	"Товхонхан" ХХК	Захирал	Сэлэнгэ, Цагааннуур
40	Дөрвөнжин	"Тусжин" ХХК	Менежер	Төв, Аргалант
41	Ширчинжав	"Хүүлийхаан" ХХК	Менежер	Төв, Цээл
42	Эрдэнэсант	"Дөлгөөнбатхаан" ХХК	Захирал	Төв, Эрдэнэсант
43	Ж.Энхцэцэг	ХХЭ	Ногоочин	Дархан-Уул, Орхон
44	Болдбат	Өндөр настан	Хувиараа	Дархан-Уул, Орхон
45	Ганзориг	ХХЭ	Ногоочин	Сэлэнгэ, Ерөө
46	Жаргалсайхан	Байхгүй	Ногоо тардаг	Дархан-Уул, Орхон
47	Цэвэлдолгор	Ногоочдын хоршоо	Ногоочин	Сэлэнгэ
48	Янжинцэцэг	ХХЭ	Ногоочин	Дархан-Уул, Орхон
49	Баасансүрэн	Ургац Ерөө хоршоо	Ногоочин	Сэлэнгэ, Ерөө
50	Д.Мандах	Тэтгэвэрт	Хувиараа	Дархан-Уул, Орхон
51	Долгорсүрэн	Ажилгүй	Хувиараа	Дархан-Уул, Орхон
52	Ламжав	"Батзол" компани	Захирал	Хөвсгөл, Тариалан
53	Дорж	ХХЭ	Ногоочин	Дархан-Уул, Орхон
54	Оюунтуяа	ХХЭ	Ногоочин	Дархан уул
55	Б.Энхтуяа	Ундрах Ерөө хоршоо	Хоршооны дарга	Сэлэнгэ, Ерөө
56	С.Лхагвамаа	ХХЭ	Ногоочин	Дархан-Уул, Орхон
57	Эрдэнэжаргал	Соёмбо түрүү ХХК	Аж ахуйн эрхлэгч	Сэлэнгэ, Ерөө
58	А.Наранцацрал	Эмнэлэг	Нягтлан боддогч	Сэлэнгэ, Ерөө
59	Б.Бямбадорж	Ногоо тарьдаг	Ногоо тарьдаг	Сэлэнгэ, Ерөө
60	Ц.Мягмарсайхан	Ногоо тарьдаг	Ногоо тарина	Дархан-Уул, Орхон
61	Хонгорзул	ХХЭ	Хувиараа	Дархан-Уул, Хонгор
62	Батсүх	"Улаантолгой" ХХК компани	Захирал	Орхон, Улаантолгой
63	Д.Цолмон	Төрийн өмчит ҮГ	Ажилтан	Говь-Алтай, Тайшир

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ, 2020 он
2. А.Бакей “Хөдөө аж ахуйн эдийн засаг”, Улаанбаатар, 2014 он, хууд. 145-149
3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын мэдээлэл, ХХААХҮЯ, 2021 он, хууд. 35
4. Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, УИХ, 2014 он, <https://www.legalinfo.mn/law/details/11485>
5. “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөр, Засгийн газар, 2017 он, <https://www.legalinfo.mn/law/details/12881?lawid=12881>
6. “Жимс, жимсгэнэ” үндэсний хөтөлбөр, Засгийн газар, 2017 он, <https://www.legalinfo.mn/law/details/12877?lawid=12877>
7. “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ыг зарлах тухай Засгийн газрын тогтоол, 2019 он, <https://www.legalinfo.mn/law/details/14938?lawid=14938>
8. Тариалангийн тухай хууль, УИХ, 2016 он, <https://www.legalinfo.mn/law/details/11641?lawid=11641>
9. Хүнсний тухай хууль, УИХ, 2012 он, <https://www.legalinfo.mn/law/details/8912>
10. Ургамал хамгааллын тухай хууль, УИХ, 2007 он, <https://www.legalinfo.mn/law/details/517?lawid=517>
11. Үрийн тариалангийн даатгалын тухай хууль, УИХ, 1999, <https://www.legalinfo.mn/law/details/14?lawid=14>
12. Таримал ургамлын үр, сортын тухай хууль, УИХ, 1999, <https://www.legalinfo.mn/law/details/471?lawid=471>
13. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, 2019, <https://www.legalinfo.mn/law/details/14848>
14. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын танилцуулга, Засгийн газар, 2019, <http://www.iltod.gov.mn/wp-content/uploads/2019/09/06>
15. Жижиг, дунд, үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль, УИХ, 2020, <https://www.legalinfo.mn/law/details/14525?lawid=14525>
16. “Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн төлөв байдал” түүвэр судалгааны дүн, Монгол банк, 2018
17. Хувь хүний орлогын албан татварын тухай болон Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга, УИХ, 2019 он, <https://www.legalinfo.mn/law/details/14410> ба <https://www.legalinfo.mn/law/details/14407>
18. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль, УИХ, 2020 он, <https://www.legalinfo.mn/law/details/11644?lawid=11644>
19. “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам”, Засгийн газар, 2019 он, <https://www.legalinfo.mn/annex/details/10058?lawid=14606>
20. “Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байга иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журам”, ХХААХҮЯ, СЯ, 2019 он, <https://www.legalinfo.mn/annex/details/10497?lawid=14982>
21. New Estimates of EU Agricultural Support: An “Un-common” Agricultural policy
22. Себастиан Маалер “Монгол Улсад тариалангийн индексжүүлсэн даатгал нэвтрүүлэх боломж”, ХХААХҮЯ, Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” төсөл, 2018 он
23. П.Эрдэнэбат “Буудай тариалдаг аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэлийн үр ашгийн шинжилгээ” сэдэвт диссертац, Улаанбаатар, 2021 он